



НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ
ШИЙДВЭР

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Эрдэнэчимэг даргалж, тус шүүхийн шүүх хуралдааны 5 дугаар танхимд нээлттэй шүүх хуралдаанаар:

Нэхэмжлэгч: “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК;

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Я.Баярсайхан

Хариуцагч: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК,

Хариуцагч: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: П.Ундрах-Эрдэнэ нарын хооронд үүссэн, “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2-т заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгуулах” шаардлага бүхий маргааныг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайхан, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Маралмаа нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг. Нэхэмжлэлийн шаардлага:

1.1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2-т заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгуулах.

Хоёр. Процессын түүх:

2.1. Хариуцагчаас нэхэмжлэгч “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийг энэхүү маргааныг урьдчилан шийдвэрлүүлэхээр Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт хандсаныг уг журмыг биелүүлсэн гэж үзэхгүй, тус хорооны дэргэдэх Маргаан таслах зөвлөлд хандаагүй тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах ёстой” гэх агуулгаар маргасныг шүүх хүлээн аваагүй болно.

010004881

2.2. Учир нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д “зөвшөөрөл эзэмшигч хооронд болон зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх” нь Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрх байхаар, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т “Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэнэ” гэж, мөн зүйлийн 33.2-т “Зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч нь Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно”¹ гэж тус тус заасан байна.

2.3. Нэхэмжлэгч “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь энэхүү маргаанаа шийдвэрлүүлэхээр 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт гэсэн хаягаар хандсан байхад тус байгууллага гомдлыг хэрхэн үзсэн талаар зохих хариу өгөөгүй байна.

2.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1-т “Хороо нь зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий Маргаан таслах зөвлөлтэй байх бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг Хороо батална” гэжээ.

2.5. Иймд “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т заасан журмын дагуу маргаанаа шийдвэрлүүлэхээр Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт хандсан байгааг хуульд заасан журмын дагуу хандсан гэж үзсэн.

2.6. Учир нь аливаа нэг байгууллагын дотоод бүтцэд хамаарах нэгжүүдийн харьяалан шийдвэрлэх асуудлыг тухайн байгууллага дотооддоо шилжүүлэн шийдвэрлэх боломжтой, эсхүл зохих нэгжид /Маргаан таслах зөвлөл/-д хандахыг албан ёсоор мэдэгдэх ёстой бөгөөд ийнхүү харьяаллын дагуу шилжүүлэх, эсхүл гомдлыг шийдвэрлэх эрх хэмжээгүй талаар мэдэгдэх зохион байгуулалтын ажлаа хийгээгүй, энэ талаар мэдэгдсэн хариу өгөөгүй нь нэхэмжлэгчийн буруутай ажиллагаа биш бөгөөд нэхэмжлэгчээс Санхүүгийн зохицуулах хороонд хандсаныг хуульд заасан журмаар хандсан гэж үзсэн ба энэхүү маргааныг урьдчилан шийдвэрлүүлэх журмыг дахин биелүүлэхийг шүүхээс шаардах эрх зүйн үндэслэлгүй гэж үзсэн болно.

2.7. Хариуцагчаас энэхүү маргааныг захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-тай зэрэгцэн хувийн өмчит “Улаанбаатар үнэт цаасны бирж” адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг 2 биржээс манайхыг сонгож бүртгүүлсэн байхад манайхыг төрийн өмчит гэдгээр захиргааны хариуцагч болгох ёсгүй” гэх агуулгаар маргасан.

2.8. Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно” гээд мөн зүйлийн 5.1.4-т “үйлчилгээг

¹ Энэ хэсгүүдэд 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.

нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, ... зэрэг байгууллагын захиргаа” гэж заажээ.

2.9."Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс төрийн эзэмшлийн хувьцааны 34 хувийг нийтэд нээлттэй санал болгож, төрийн болон хувийн холимог өмчийн хуулийн этгээд болж, эрх зүйн байдалд нь өөрчлөлт орсон байгаа боловч Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар "зохицуулалттай үйл ажиллагаа явуулдаг", мөн хуулийн 47.2-т зааснаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах эрх хэмжээтэй, мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т зааснаар үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй хуулийн этгээд мөн тул Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн болон холимог өмчийн байгууллага” гэж үзэх тул "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК энэ хэргийн хариуцагч мөн бөгөөд маргаан нь захиргааны хэргийн харьяалан шийдвэрлэх хэрэг мөн байна.

2.10.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн 221/2022/0003/3 индекстэй хэрэгт захиргааны актын хариуцагчаар "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийг хариуцагч мөн гэж үзэн хэргийн хариуцагчаар татан оролцуулсан хүчин төгөлдөр шүүгчийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 45 дугаар захирамж байна.

Гурав.Нэхэмжлэгч "Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК шүүхэд бичгээр ирүүлсэн нэхэмжлэлдээ:

3.1."Монголын хөрөнгийн бирж " ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар "Хамтын хаалттай Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг баталж, уг журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтаар "нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсийг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1% байхаар журамлан тогтоосон талаар;

3.2.Энэхүү журамд үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд нь сангийн нэгж эрхийг бүртгүүлэхдээ нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувийг үйлчилгээний хөлсөнд төлөхөөр хатуу тогтоосон нь илт эдийн засгийн үндэслэлгүй гэж үзэж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.18-д "үнэт цаасны зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас тогтоосон зах үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санал болгох, энэ саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох, энэ тухайгаа нийтэд мэдээлэх", 74 дүгээр зүйлийн 74.4-т "Хороо хууль тогтоомжтой зөрчилдсөн дүрэм, журмыг бүхэлд нь, эсхүл тэдгээрийн зарим заалтыг өөрчлөх даалгавар өгч болно", 75 дугаар зүйлийн 75.2-т "Өөрийгөө зохицуулах байгууллагын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд Хороо шалгалт хийнэ", мөн зүйлийн 75.4-т "Өөрийгөө зохицуулах байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн нь энэ хууль, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд Хороо дараах арга хэмжээ авч, нийтэд мэдээлнэ", мөн зүйлийн 75.4.2-т "даалгавар өгөх" гэж тус тус заасныг үндэслэн "нэгж эрхийн үнийг бүртгүүлэх үйлчилгээний хөлс 1 хувь байхаар журамласан заалтыг эс зөвшөөрч, уг хувь хэмжээнд өөрчлөлт оруулах тухай хүсэлтээ эрх ашгаа хамгаалуулахаар нэгдэж, гишүүн нь болсон "Монголын үнэт

цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо" төрийн бус байгууллагаар дамжуулан Монгол улсын Сангийн сайд Б.Жавхлан, СЗХ-ны дарга Д.Баярсайхан нарын нэр дээр 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 116 тоот албан бичгээр, Монголын Хөрөнгийн бирж-д 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 118 тоотгоор, манай хөрөнгө оруулалтын менежментийн компани болох "Мандал ассет менежмент ҮЦК" ХХК-иар дамжуулан 2021 оны 06 дугаар сарын 16-ны 21/015, 8 дугаар сарын 16-ны өдрийн 21/069, " Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Сүх-Очирт 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 21/140 тоот албан бичгүүдээр удаа дараа хүсэлт гаргасан талаар;

3.3.Дахин "Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС "-аас 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 21/203 тоот албан бичгээр Үйлчилгээний хураамжийг хүчингүй болгуулах талаар хандахад Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 1/4258 тоот албан бичгээр "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн гүйцэтгэх захиралд 2021 оны 12 дугаар сарын 20-н хүртэл хугацаатай чиглэл өгсөн боловч хэрэгжүүлээгүй тул Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан 2021 оны 12 дугаар сарын 22-ы өдөр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтын "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн "6.2.2. Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%" гэснийг хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гаргасан талаар;

3.4.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх хугацаанд "Монголын хөрөнгийн бирж "ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын Зургаа дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор:

Журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт "нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь "гэснийг" Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс- Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч:

6.2.2.1. 20 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.5 хувь,

6.2.2.2. 20-50 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.375 хувь,

6.2.2.3. 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд 0.25 хувь гэж өөрчлөлт оруулан Санхүүгийн Зохицуулах Хороогоор баталгаажуулсан тул нэхэмжлэлийн шаардлага хангагдсан гэж үзэж нэхэмжлэлээсээ татгалзсан талаар;

3.5.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 20 дугаартай "Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" захирамж гарсан талаар;

3.6."Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн зүгээс -Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын Зургаадугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад өөрчлөлт орсон тул дээрх өөрчлөлт орсон журмын заалтын дагуу нэгж эрхийн бүртгэлийн хөлсийг төлөх тухай хүсэлтээ "Монголын хүсэлтийг оны хөрөнгийн бирж" ТӨХК-д 2022 оны 08 сарын 01-ны өдрийн 22\069 тоот албан бичгээр гаргасан боловч хариу мэдэгдэлгүй эс үйлдэхүй гаргасан тул энэхүү нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан талаар;

3.7. Монгол улс нь 1991 онд улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулснаар хөрөнгийн зах зээлийн эхлэл тавигдсан ба энэхүү харилцаа манай улсын хувьд хөгжлийнхөө дөнгөж эхлэл шат буюу 30 дахь жилд яваа бөгөөд 2017 оноос хойш хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд оролцох ойлголт сайжирч, идэвх нь нэмэгдэх хандлагатай болсон. "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан хамгийн том хөрөнгө оруулалтын сан гэж одоогоор тооцогдож байгаа талаар;

3.8. Хөрөнгийн зах зээл үүсгэн байгуулагдсанаас хойш одоог хүртэл хөрөнгийн зах зээл дэх бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн зөв зохистой харьцаа бүрэлдэхгүй байсаар ирсэн бөгөөд энэ салбарын зохицуулалт одоогоор хангалттай төлөвшөөгүй байгаа тул төрийн зохицуулалт шаардлагатай, төрөөс дэмжлэг үзүүлэх салбар мөн билээ.

3.9. Ийм ч учраас хууль тогтоогч нараас Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т "Хөрөнгийн бирж үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй" байхаар хуульчлан тогтоож өгсөн гэж;

3.10. Дээрх хуулийн заалтаар Хөрөнгийн биржид үйлчилгээний хөлс тогтоох эрхийг олгосон боловч тус байгууллага нь энэхүү эрхийг аливаа хязгааргүйгээр эдлэх ёстой гэсэн ойлголт огт биш гэдэг нь мөн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан үзэл баримтлалаас харагдах болно.

Энэ ч учраас "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1 дүгээр хавсралтаар хувьцаа болон бонд бүртгүүлэхэд төлөх бүртгэлийн үйлчилгээний хөлсийг 0,1 хувь, нийтдээ 50,000,000 саяас ихгүй байхаар "анх тогтоосон" гэж;

3.11. Энэхүү журам нь Үнэт цаас гаргагчийн анх удаа болон нэмж гаргасан хувьцаа, ерийн хэрэгслийг "Монголын хөрөнгийн бирж"-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой журам гэж;

3.12. Хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь тодорхой хууль зүйн болон бусад эдийн засаг, санхүүгийн үндэслэл, шаардлага шалтгаангүйгээр 2019 онд "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг шинээр батлахдаа сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хураамжийг 1 хувь болгож нэмэгдүүлснээр өөрийн хуульд заасан эрхээ эдэлж байгаа мэт боловч эдийн засгийн тооцоо, судалгаа, үндэслэлгүйгээр үйлчилгээний хөлсийг нэмж тогтоосноор хөрөнгийн зах зээлд оролцогч илт хохироосон, алдагдалд хүргэж болзошгүй зохицуулалт болсон гэж;

3.13. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд "Үнэт цаас" гэдэгт дараах компанийг эдийн засгийн хувьд санхүүгийн хэрэгсэл хамаарахаар заасан" гээд

1. хувьцаат компанийн хувьцаа /цаашид "хувьцаа" гэх/;

2. компанийн өрийн хэрэгсэл;

3. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;

4. хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх;

5. хадгаламжийн бичиг;

6. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

7. Үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх /варрант/;

8. Үүсмэл санхүүгийн хэрэгсэл; зэрэг байхаар заасан талаар;

3.14. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь хувьцаа ба бондын хураамжийг 0,1 хувь буюу 50 сая төгрөгөөс хэтрэхгүй гэж тогтоосон боловч сангийн нэгж эрхийг 1 хувь байхаар тогтоосон нь шударга бус байсан ба хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндөж, хохироох нөхцөлд хүргэсэн. Хувьцаа, бонд, сангийн нэгж эрх болон аливаа үнэт цаасыг бүртгэх үйлчилгээ нь үнийн дүнгээс үл хамаарсан нэг л үйл ажиллагаа бөгөөд түүнийг бүртгэж, материал бүрдүүлэх зэрэг цөөн Хэдхэн ажиллагаа явагддаг юм. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь ийм буруу журам гаргаснаа хүлээн зөвшөөрсөн нь сая журмаа өөрчилснөөр нотлогдоно гэж;

3.15. Манай хөрөнгө оруулалтын сан нь 7,000 орчим нэгж эрх эзэмшигчтэй ба эдгээр иргэдээс санд төвлөрүүлсэн 50,000,000,000 /Тавин тэрбум төгрөгөөс арилжааны шимтгэл хэлбэрээр 376,000,000 төгрөгийг төлсөн бөгөөд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2-д заасан нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсийг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%" гэсэн заалтын дагуу" нэгж эрх бүртгүүлэхэд төлөх хураамж 500,000,000 төгрөгийг нэмж төлсөн тохиолдолд нийт иргэдийн төвлөрүүлсэн сангийн хөрөнгөөс 876 сая төгрөгийг шууд төлбөр хураамж нэрээр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК суутган авч санг эхнээс нь алдагдалд хүргэх сөрөг үр дагавартай тул дээрх журмын заалтыг эс зөвшөөрч хүчингүй болгуулахаар Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар нэхэмжлэлийн шаардлага гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх хугацаанд Монголын хөрөнгийн бирж" ТӨХК журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт бүхэлд нь өөрчлөлт оруулан одоо мөрдөж ажиллаж байгаа гэж;

3.16. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-н Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтын "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын Зургаа дугаар зүйлийн "6.2.2. Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%" гэсэн журмын заалтын дагуу үйлчилгээний хөлс төлсөн тохиолдолд нэгж эрх эзэмшигч хөрөнгө оруулагч 7000 орчим иргэний эрх ашигт сөргөөр нөлөөлж, хөрөнгийн зах зээлийн харилцаанд шууд оролцогч манай компанийг эдийн засгийн хувьд алдагдалд оруулж болзошгүй гэж;

3.17. Дээрх үндэслэлээр "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн үйлчилгээний хөлсийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг "Монголын Хөрөнгийн

бирж” ТӨХК-д даалгуулахаар энэхүү нэхэмжлэлийн шаардлагыг гаргаж байна гэжээ.

3.18. *Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайхан шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:*

“Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгуулах шаардлага гаргасан. Манай компани нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулахаар Компанийн тухай хуульд заасан журмын дагуу 2021 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулагдаж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу бүртгэл хийлгэх зохих баримт бичгийг бүрдүүлэх зорилгоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас гаргасан дүрэм, журмуудтай танилцаж, анх бүртгүүлэхээр тус байгууллагад хандсан боловч хариу өгөхгүй эс үйлдэхүй гаргасан учраас шүүхэд нэхэмжлэл гаргасан. Захиргааны ерөнхий хуулийн 5.4 дэх хэсэгт зааснаар нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно. Үнэт цаасны тухай хуулийн 1.1 дэх хэсэгт үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж заасны дагуу энэ бол захиргааны хэргийн маргаанд хамаарна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1.2-т үнэт цаасны зах зээлийн тогтолцооны эрсдэлийг бууруулах, шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах зарчмыг баримтална гэж заасан. Монгол Улсад өмч хувьчлалын ажлыг 1991 оноос эхлүүлсэн. Нэхэмжлэгч нэхэмжлэл гаргахдаа Монголын хөрөнгийн биржийн үйлчилгээний бүртгэлийн журамд заасан хэмжээ дээрх хөрөнгө оруулалтын санг албан ёсны эрсдэлд оруулах магадлалтай. Нийт 7000 орчим эрх эзэмшигчтэй ба санд төвлөрүүлсэн 50 тэрбум төгрөгөөс арилжааны шимтгэл хэлбэрээр санд 376 сая төгрөгийг тушаасан. “Мандал ирээдүйн өсөлт хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан” ХХК нь өөрийн арилжааны шимтгэлийн хэлбэрээр болон 1 жилд эрхийн бүртгэл хийлгэхэд хөрөнгийн биржид 876 000 000 төгрөг төлөх тооцоолол гарсан. Ингэж төлснөөр хамтын сангийн үйл ажиллагаа доголдож хүндрэлтэй байдалд орохоор байсан. 2021 онд журмын 6.2-т заасан заалтыг хүчингүй болгуулахаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар нэхэмжлэл гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК өөрийн журамдаа өөрчлөлт оруулж бүртгэлийн хураамжийг үнийг буулгасан. Шинэ зохицуулалтаар хийгдсэн бүртгэх эрхийн журмаар хураамжийг аваач гэдэг байдлаар хандсан боловч хариу өгөлгүй эс үйлдэхүй гаргасан.

2021 оны 07 сард бүртгүүлэхээр Монголын хөрөнгийн биржид хандаад гэрээг тухайн үедээ байгуулсан. Түүнээс хойш хураамж хэт өндөр байна гэдэг зүйл яригдсан. Монголын хөрөнгийн бирж хувьцаа бонд зэргийг бүртгэхдээ 0.1 хувиар бүртгээд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэхдээ 1 хувиар бүртгэхээр заасан. 1.2-1.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилладаг. Үүнийгээ нөхөхийн тулд

өндөр хэмжээгээр авдаг гэж тайлбарладаг. Нэг талаасаа алдагдлаа нөхөх, нөгөө талаасаа өөрийгөө санхүүжүүлэх үйлчилгээний хөлсийг эндээс гаргуулж авах байдлаар ханддаг юм биш биз гэсэн хардлага байна. Манай 2 байгууллагын төлбөрийн асуудал дээр маргаан үүсээгүй байсан. Хураамж өндөр байна буулгаач гэсэн хүсэлтийг манай талаас тавьсан. Маргаан таслах зөвлөлийн Үнэт цаасны хороонд энэ саналаа тавихад буулгах боломжгүй гэсэн. Санхүүгийн зохицуулах хороо тайлбартаа хөрөнгийн биржээс баталж ирүүлсэн журмыг манай хороо өөрчлөх боломжгүй, манайх зөвхөн батламжилдаг гэсэн. Санхүүгийн зохицуулах хороонд албан бичиг өгсөн боловч бидэнд 30 хоногийн дотор хариу өгөөгүй учраас эс үйлдэхүй гаргалаа гэдэг байдлаар шүүхэд хандсан. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлнэ гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа. Монголд хөрөнгө, бондын худалдаа хөрөнгийн бирж дээр л явагддаг. Төлөөлөн удирдах зөвлөл Сангийн яамнаас томилогддог. Хөрөнгийн биржийн гаргасан журам Захиргааны ерөнхий хуулийн 5.8-д заасан журамласан захиргааны актын хэлбэртэй. Тийм учраас захиргааны актын маргаан мөн. Монгол Улсыг хөгжүүлэе гэвэл хөрөнгө оруулалтын санг дэмжих ёстой. Хөрөнгийн бирж эсрэгээрээ авсан хураамжаараа өөрсдөө яаж алдагдалгүй ажиллах вэ гэдэг байдлаар л хандаад байна. Манайх Хөрөнгийн биржээс гадна олон байгууллагад хураамж төлдөг. Бидний үйл ажиллагааг дэмжих ёстой байтал эсрэгээрээ устгах төрлийн үйл ажиллагаа явуулаад байгааг анхаарч үзээч гэв.

3.19.Нэхэмжлэгчээс энэхүү маргаан нь захиргааны шүүхийн харьяаллын болох талаар дараах үндэслэлийг гаргасан байна. Үүнд:

Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно" гээд мөн зүйлийн 5.1.4-т "үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа" гэж тус тус заасан талаар;

3.20.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж, 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулиар үнэт цаасныг нийтэд санал болгон гаргах, арилжих, бүртгэх, төлбөр, тооцоог гүйцэтгэх, хадгалах, бусад зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна" гэж, мөн зүйлийн 3.4-т "Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон нийтлэг Харилцааг энэ хуулиар, ... зохицуулна" гэж заасан талаар;

3.20.Эдгээр заалтуудаас үзвэл үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогч олон нийтэд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нийтлэг үйлчилгээ үзүүлдэг, нийтээс тус компанийн Үйлчилгээг нь авдаг гэдгийг тодорхойлсон гэж;

3.21."Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 1.2-д "Энэхүү журмыг Биржийн нэгж эрхийн бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан, түүнийг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон бусад эрх бүхий албан тушаалтан, аудитор, хуульч,

хөрөнгийн үнэлгээчин болон холбоотой бусад эд дагаж мөрдөнө" гэж заасан нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт болохыг тогтоосон гэж;

3.22.Иймд нэхэмжлэгчээс энэхүү хэм хэмжээ тогтоосон журмаар үйлчилгээний хөлс авах нь захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх захиргааны акт мөн гэж үзсэн болно гэжээ.

Дөрөв.Хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ шүүхэд бичгээр гаргасан тайлбар болон шүүх хуралдаанд гаргасан хариу тайлбартаа:

4.1.Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны талаар: "Монголын хөрөнгийн бирж нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад заасан үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий төрийн өмчит хуулийн этгээд гэж;

4.2.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлд зааснаар Санхүүгийн зохицуулах хороо, түүний Маргаан таслах зөвлөл нь үнэт цаасны зах зээлд гарсан маргаантай асуудлыг тэргүүн ээлжид шийдвэрлэдэг талаар;

4.3."Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК нь нэхэмжлэлд дурдсан асуудлаараа 2022 оны 08-р сарын 16-ны өдрийн дугаар 22/80 тоот албан бичгээр Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт хандсан байна. Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газар нь үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаанд төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлдэг ажлын алба бөгөөд түүнд зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэх бүрэн эрх хуулиар олгогдоогүй гэж;

4.4.Иймд "Мандал ирээдүйн өсөлт" ХХОС нь "Монголын хөрөнгийн бирж"- ийн үйлчлүүлэгч, нөгөө талаар үнэт цаасны зах зээлд оролцогчийн хувьд нэхэмжлэлд дурдсан асуудлаараа хуульд заасан захиргааны урьдчилсан шийдвэрлэх ажиллагаа хийлгээгүй, маргааныг урьдчилан шийдвэрлэх эрх бүхий Санхүүгийн зохицуулах хорооны Маргаан таслах зөвлөлд хандаагүй байна гэжээ.

4.5.Хариуцагч мөн түүнчлэн захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан биш гэж үзсэн талаараа: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1-д зааснаар үнэт цаасны 17 зохицуулалттай үйл ажиллагаа байдаг.

Дээр дурдсан 17 үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулах ба төрийн өмчит хуулийн этгээд эсхүл хувийн хэвшлийн байгууллага аль аль нь эрхлэн явуулах боломжтойн зэрэгцээ үүнд өмчийн хязгаарлалт тогтоогоогүй. Эдгээрийн зөвхөн нэг үйл ажиллагаа нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК- ийн явуулж буй үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа юм. Монгол Улсад өнөөдрийн байдлаар 2 арилжаа эрхлэх байгууллага Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК (хувийн хэвшлийн байгууллага)-ын талаар;

4.6.Эндээс үзвэл Захиргааны ерөнхий хуулийн 5.1.4-т заасан "үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг" гэх захиргааны байгууллагын шинж хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувьд тогтоогдохгүй байх ба ижил чиглэлийн

үйл ажиллагаа явуулж буй өмчийн өөр хэлбэрийн бирж мөн зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь хувийн эрх зүйн салбар буюу үнэт цаасны зах зээлийн харилцаанд бусад хувийн хэвшлийн зарим байгууллагатай өрсөлдөн ажилладаг байгууллага юм. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг төрийг төлөөлж Монгол Улсын Сангийн яам хэрэгжүүлж, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг Сангийн яамнаас томилогдсон этгээдүүд хэрэгжүүлдэг. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувьцааг төр эзэмшдэг боловч эрх зүйн байдлын хувьд нь үнэт цаасны арилжаа эрхлэгч бусад хувийн хэвшлийн байгууллагаас илүү эрх хэмжээ эдэлдэггүй ба бусад үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын адил Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад үйл ажиллагаагаа явуулдаг гэж;

4.7.Төрийн өмчит "Монголын хөрөнгийн бирж" компани болон хувийн хэвшлийн "Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК яг адилхан эрх зүйн статустай байгууллага юм. Төр аливаа компанийн хувьцааг эзэмшдэг байснаараа тухайн компани захиргааны байгууллага гэж тооцогдохгүй гэж;

4.8. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-иас зөвхөн өөрийн биржид бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд зориулан журам баталсан нь, нийтээр дагаж мөрдөх гадагш чиглэсэн үйлчлэлгүй, дотогшоо чиглэсэн үйлчлэл бүхий акт тул захиргааны хэмжээний акт гэж тооцогдохгүй гэж үзэж байгаа талаар;

4.9.Иймд хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь Захиргааны ерөнхий хуулийн 5.1.4-т заасан "үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг" захиргааны байгууллага биш бөгөөд зөвхөн манай хөрөнгийн биржид бүртгүүлсэн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх "Хамтран хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгжийн эрхийн бүртгэлийн журам нь захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх захиргааны акт биш гэж;

4.10.Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6 сарын 28-ний өдрийн тогтоолоор баталсан. Тухайн журмын үйлчлэх хүрээ нь зөвхөн өөрийн биржид бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд чиглэсэн, бүх нийтээр дагаж мөрдөх гадагш чиглэсэн эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчлэхэд чиглээгүй, дотогшоо чиглэсэн үйлчлэл бүхий акт тул Монгол Улсын захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлгүй гэж;

4.11.Дээр дурдсанчлан Монгол Улсын үнэт цаасны зах зээлд 17 төрлийн байдаг бөгөөд уг зохицуулалттай ажиллагаа зохицуулалттай үйл этгээдүүдийн үйл ажиллагаа буюу: (1) Үнэт цаасны брокер, (2) диллер, (3) андеррайтер. (4) хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, (5) үнэт цаасны итгэмжлэн удирдах, (6) үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх гэх мэт эдгээр үйл ажиллагаа эрхлэгч нь бүгд өөр өөрийн харилцагч, үйлчлүүлэгч нарт чиглэсэн дотоод дүрэм журамтай. Эдгээр байгууллагуудын дүрэм журам нь тухайн зохицуулалттай этгээдийн зөвхөн өөрийнх нь харилцагч үйлчлүүлэгчийн хүрээнд мөрдөгдөх дотогшоо чиглэсэн үйлчлэл бүхий хэм хэмжээний акт тул Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлгүй гэж;

4.12.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.3 дахь хэсэгт "Хөрөнгийн бирж үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй" гэж заасан. Үүний дагуу "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн

удирдах зөвлөлийн 2019 оны 6 сарын 28-ний өдрийн тогтоолоор Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг батлахдаа бүртгэх үйлчилгээний хөлсийг 1 хувиар тогтоож, журмыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн талаар;

4.13. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 62.1 дэх хэсэгт зааснаар "Үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага" нь Санхүүгийн зохицуулах хороо бөгөөд мөн хуулийн 49.1.4-д Санхүүгийн зохицуулах хороо нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн дүрэм, журмыг батламжлахаар заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо уг журмыг хүлээн авч, батламжилсан талаар;

4.14. Үүнээс үзвэл нэхэмжлэгч "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэхэмжлэлийн үндэслэлдээ хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" нь үйлчилгээний хөлс тогтоох эрхээ хязгаарлалтгүйгээр эдэлж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т "Энэ хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зээлийн тогтолцооны эрсдэлийг бууруулах, шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах зарчмыг баримтална" гэж заасныг баримтлалгүйгээр сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хураамжийг 1% -иар тогтоосон гэж тайлбарласан нь үндэслэлгүй гэж;

4.15. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь бүртгэх үйлчилгээний хөлсийг Засгийн газрын бодлого, хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд нийцүүлж боломжит хэмжээнд бууруулах байр суурьтай байдаг бөгөөд ийм ч үүднээс "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, гүйцэтгэх удирдлагын зүгээс үйлчилгээний хөлсний хувь хэмжээг бууруулах асуудлыг эрх бүхий субъект болох Төлөөлөн удирдах зөвлөлдөө удаа дараа оруулж хэлэлцүүлж байсан талаар;

4.16. Үүний дагуу Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дах хэсэгт "нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1% байна" гэж заасан хувь хэмжээг дараах байдлаар бууруулан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 сарын 30-ний өдрийн 16 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан болно.

Үүнд: Тус журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дах хэсэг "Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс -Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч, 20 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.5%, 20-50 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.375%, 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд 0.25% тус тус байх ба хамгийн багадаа 25,000,000 төгрөг, хамгийн ихдээ 150,000,000 төгрөг" байхаар нэгж бүртгэлийн үйлчилгээний хөлс өөрчлөгдсөн талаар;

4.17. "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хөрөнгө оруулалтын сан нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-тай 2021 оны 7 сарын 22-ны өдөр бүртгэлийн гэрээ байгуулж, ус биржийн бүртгэлд бүртгэгдсэн. Өөрөөр хэлбэл, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 6 28-ний өдрийн 2019/07 дугаартай тогтоолоор батлагдсан үйлчилгээний хөлс мөрдөгдөж байх үед "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д бүртгэгдсэн, бүртгэлийн гэрээ байгуулсан тул тухайн үед хүчинтэй байсан журмын дагуу бүртгэлийн үйлчилгээний хөлсийг тооцон төлөх үндэслэлтэй гэж;

4.18. Түүнчлэн талуудын хооронд байгуулагдсан бүртгэлийн гэрээний 2.1.2-т зааснаар бүртгэх үйлчилгээний хөлсийг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувиар

тогтоосон байдаг. Нэхэмжлэгч байгууллага нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн журамд заасан үйлчилгээний хөлс, хэмжээг урьдчилан мэдэж, ойлгож, харилцан зөвшөөрч бүртгэлийн гэрээ байгуулсан гэж;

4.19.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсний хувь хэмжээ өөрчлөгдсөн нь гагцхүү батлагдсан үеэсээ хүчин төгөлдөр болох ба батлагдахаас өмнөх хугацаанд ухарч үйлчлэхгүй талаар;

4.20.Харин Санхүүгийн зохицуулах хорооноос "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 сарын 30-ний өдрийн 16 дугаар тогтоолоор батлагдсан хувь хэмжээгээр "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-иас бүртгэх үйлчилгээний хөлсийг хураах талаар шийдвэр гаргасан тохиолдолд бид эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, зохих ёсоор шийдвэрлэх боломжтой юм.

4.21.Дээр дурдсан нөхцөл байдалд үндэслэн "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ны 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг даалгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг өнөөдрийн байдлаар хүлээн зөвшөөрөх боломжгүй байна гэв.

4.22. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулсан гэдэг боловч хаана хандсан нь тодорхойгүй, хууль ёсны дагуу явуулаагүй гэж үзэж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад заасан үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий төрийн өмчийн хуулийн этгээдээр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК ажиллаж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйл, 88 дугаар зүйлд заасны дагуу урьдчилан шийдвэрлэх байгууллага бол Санхүүгийн зохицуулах хороо түүний Маргаан таслах зөвлөл шийдвэрлэдэг.

Урьдчилан шийдвэрлэх ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт хандсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар 17 төрлийн зохицуулалттай үйл ажиллагаа байна. Үүнд үнэт цаасны брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, үнэт цаасны итгэмжлэн удирдах, андеррайтер, үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл, үнэт цаасны арилжааны тооцоо, үнэт цаасны арилжааны төлбөр, үнэт цаасны төвлөрсөн хадгаламж, кастодиан, арилжаа эрхлэх, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежмент, санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох, оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх, зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх зэрэг олон ажил байдгаас зөвхөн нэг нь үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа байгаа. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг байснаар захиргааны байгууллага болохгүй. Монгол Улсад үнэт цаасны арилжаа эрхэлдэг Улаанбаатар үнэт цаасны 2 бирж гэж бий. Энэ хоёр биржээс нэхэмжлэгч нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийг сонгон бүртгүүлсэн. Хувьцааг нь төрийг төлөөлж Сангийн яам эзэмшдэг. 2023

онд биржийн 34 хувийг олон нийтэд санал болгосон. Хувьцааны 64 хувийг төр эзэмшдэг боловч бусад байгууллагаас илүү эрх хэмжээ эдэлдэггүй. Зөвхөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар эзэмшдэг. Хянагч байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо. Яг адил статустай ялгаа нь нэг нь хувийн эзэмшлийнх, нөгөө нь төр болон хувийн эзэмшлийнх. Төр эзэмшдэг байснаараа захиргааны байгууллага болохгүй. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын эрх зүйн үйлчлэлийн тухайд хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 сарын 28-ний өдрийн тогтоолоор баталсан байдаг. Тухайн журмын үйлчлэх хүрээ нь зөвхөн өөрийн биржид бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд чиглэсэн, бүх нийтээр дагаж мөрдөх гадагш чиглэсэн эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчлэхэд чиглээгүй, дотогшоо чиглэсэн үйлчлэл бүхий акт тул Монгол Улсын захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлгүй. Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журамд заасан бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооноос хянаж батламжилсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.3 дахь хэсэгт “Хөрөнгийн бирж үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй” гэж заасан. Үүний дагуу Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 сарын 28-ний өдрийн тогтоолоор Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг батлахдаа бүртгэх үйлчилгээний хөлсийг 1 хувиар тогтоож, журмыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн байдаг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт зааснаар “Үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага” нь Санхүүгийн зохицуулах хороо бөгөөд мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.4-д Санхүүгийн зохицуулах хороо нь арилжаа эрхлэх байгууллагуудын дүрэм, журмыг батламжлахаар заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо уг журмыг хүлээн авч, батламжилсан.

Үүнээс үзвэл нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь нэхэмжлэлийн үндэслэлдээ хариуцагч “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь үйлчилгээний хөлс тогтоох эрхээ хязгаарлалтгүйгээр эдэлж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “Энэ хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлийн тогтолцооны эрсдэлийг бууруулах, шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах зарчмыг баримтална” гэж заасныг баримтлалгүйгээр сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хураамжийг 1%-иар тогтоосон гэж тайлбарласан нь үндэслэлгүй байна.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь бүртгэх үйлчилгээний хөлсийг Засгийн газрын бодлого, хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд нийцүүлж боломжит хэмжээнд бууруулах байр суурьтай байдаг бөгөөд ийм ч үүднээс “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, гүйцэтгэх удирдлагын зүгээс үйлчилгээний хөлсний хувь хэмжээг бууруулах асуудлыг эрх бүхий субъект болох төлөөлөн удирдах зөвлөлдөө удаа дараа оруулж хэлэлцүүлж байсан.

Үүний дагуу Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дах хэсэгт “нэгж эрх бүртгэх

үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1% байна” гэж заасан хувь хэмжээг бууруулан Монголын Хөрөнгийн биржийн ТУЗ-ийн 2021 оны 12 сарын 30-ний өдрийн 16 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан. Журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэг “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс -Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч, 20 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.5%, 20-50 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.375%, 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд 0.25% тус тус байх ба хамгийн багадаа 25 000 000 төгрөг, хамгийн ихдээ 150 000 000 төгрөг” байхаар нэгж бүртгэлийн үйлчилгээний хөлс өөрчлөгдсөн. “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-тай 2021 оны 7 сарын 22-ны өдөр бүртгэлийн гэрээ байгуулж, тус биржийн бүртгэлд бүртгэгдсэн. Энэ нь өөрчлөгдсөн цаг хугацаанаас өмнөх нөхцөл байдалд хамаар байгаа. Өөрөөр хэлбэл “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 05 сарын 28-ны өдрийн 2019/07 дугаартай тогтоолоор батлагдсан үйлчилгээний хөлс мөрдөгдөж байх үед Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэж бүртгэлийн гэрээ байгуулсан. 1 хувь гэх үйлчилгээний хөлс, хэмжээг урьдчилан мэдэж ойлгож, харилцан зөвшөөрсөн. 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсний хувь хэмжээ өөрчлөгдсөн нь гагцхүү батлагдсан үеэсээ хүчин төгөлдөр болох ба батлагдахаас өмнөх хугацаанд ухарч үйлчлэхгүй. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэв.

ҮНДЭСЛЭХ НЬ:

Нэг.Маргааны зүйл, эрх зүйн харилцааны төрөл:

1.1.Нэхэмжлэгч “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн сүүлд баталсан журмыг баримтлан үйлчилгээний хөлс төлөх ёстой гэх агуулгаар маргасан.

Хоёр.Шүүхэд тогтоогдсон үйл баримтын талаар:

2.1.“Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр үүсгэн байгуулагдаж, мөн оны 05 дугаар сарын 18-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, 6702988 дугаар регситрын дугаартай хуулийн этгээд байна. /ХХ-1-н 10 дахь тал/

2.2.“Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн дүрэм, хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэснээр тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 50,000,000,000 /Гавин тэрбум/ төгрөг байна.

2.3.“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг баталж, уг журмын 6.2.2-т “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%” гэж тогтоож мөрдсөн байна.

2.4.Ийнхүү тус компани үүсгэн байгуулагдаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж байх цаг үед дээрх 2019 оны журам үйлчилж байсан бөгөөд уг журмын 6.2.2-т заасны дагуу “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-иас “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д бүртгүүлэхдээ үйлчилгээний хураамжид 500,000,000 /Гаван зуун сая/ төгрөг төлөхөөр байжээ.

2.5. "Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК нь уг хураамжийн хэмжээг тодорхой хууль зүйн болон эдийн засгийн, санхүүгийн үндэслэл тооцоогүй, шалтгаан нь тодорхойгүй хэт өндөр тогтоосон, хөрөнгийн зах зээлд оролцогч компанийг илтэд хохироосон, алдагдалд хүргэсэн гэх үндэслэлээр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6.2.2-т "Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%" гэж өөрчлөлт оруулсныг хүчингүй болгуулахаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр нэхэмжлэл гаргасан байна.

2.6. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байх шатанд буюу 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 16 дугаар тогтоолоор "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6.2.2-ын "Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%" гэснийг өөрчлөн "Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч:

6.2.2.1. 20 тэрбум хүртэлх үнийн дүнд 0,5%,

6.2.2.2. 20-50 тэрбум хүртэлх үнийн дүнд 0,375%

6.2.2.3. 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд 0,25%" болгож тогтоожээ.

2.7. Дээрх шийдвэрийг үндэслэн нэхэмжлэгч "Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан "... энэхүү өөрчлөлт орсноор манай гаргасан нэхэмжлэлийн шаардлага бүрэн хангагдсан" гэх үндэслэлээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66.1, 66.2-т заасныг үндэслэн нэхэмжлэлээсээ татгалзсаныг тус шүүхийн шүүгчийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 20 дугаар захирамжаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн үйл баримт тогтоогдлоо.

Гурав.Маргаан бүхий актыг хянасан, шүүхээс хууль хэрэглэсэн үндэслэлийн тухайд:

3.1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2018/07 дугаартай тогтоолоор баталсан үйлчилгээний хөлс мөрдөгдөж байх үед "Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэгдсэн учраас, тухайн үед хүчинтэй байсан журмын дагуу бүртгэлийн хураамж төлнө" гэх үндэслэлээр хариуцагчаас ***"нэхэмжлэгчийг шинээр бууруулж тогтоосон хувь хэмжээгээр үйлчилгээний хураамж төлүүлэхээс татгалзсан"*** шийдвэрийг маргаан бүхий захиргааны акт гэж үзсэн.

3.2. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь "Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн нэхэмжлэлээр үүссэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад "Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс"-ийг бууруулж тогтоосон бөгөөд уг хэрэгт оролцож буй хариуцагчийн хувиар нэхэмжлэгчийг шинээр тогтоосон үйлчилгээний хөлсний хувь хэмжээгээр төлбөр төлөх ёсгүй гэж үзсэн бол тухайн хэрэгт энэ талаар үндэслэлээ гаргаж, маргааныг эцэслэн шийдвэрлүүлээгүй, нэхэмжлэгчид "шинээр тогтоосон үйлчилгээний

хөлсний хувь хэмжээгээр төлнө” гэх итгэл төрүүлж, түүнийг нэхэмжлэлээсээ татгалзахад хүргэж, ингэж татгалзсан нь нь шүүхэд уг журмаар тогтоосон “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%”-ыг үндэслэлтэй тогтоосон, нэхэмжлэгч энэ хэмжээгээр төлөх хууль зүйн үндэслэлтэй эсэх талаар дахин маргах эрхгүй болгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д заасан “хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”-ыг алдагдуулсан, хууль бус ажиллагаа байна.

3.3.Нөгөө талаас “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоороо “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүн”-г бууруулж тогтоохын тулд явуулсан арга хэмжээнийхээ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороонд хандан хүргүүлж байсан 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 01/410 дугаартай албан бичиг хүргүүлж байжээ.

3.4.Уг албан бичигт “... “Монголын хөрөнгийн бирж” нь зохицуулагч болон зах зээлд оролцогч байгууллагуудын санал, хүсэлт, санхүүгийн нөөц боломж зэргийг харгалзан ... бууруулж, үнэт цаасны бүртгэлийн хураамжийг ... бууруулахаар ажиллаж байна”, “... хамтын сангийн нэгж эрхийн бүртгэх үйлчилгээний хөлсийг дорвитойгоор бууруулахаар төлөвлөж байна”, “... Цаашид шимтгэл, хураамжийг нийт зах зээлийн хэмжээнд дорвитой бууруулж, хөгжлийг нь түргэтгэхийн тулд бодлогын зохицуулалт хийх шаардлага тулгараад байна” гэж дурдсанаас үзвэл хамтын сангийн нэгж эрхийн бүртгэх үйлчилгээний хөлс нь уг зах зээлд оролцогч компаниудын хөгжилд нөлөөлж байгаа болохыг мэдсэн, энэ талаар бодлогын зохицуулалт хийсэн буюу “захиргааны актыг гаргах зорилго” нь энэ бичгээс тодорхой харагдаж байна.

3.5.Түүнчлэн хариуцагч шүүхэд бичгээр гаргасан тайлбартаа болон мэтгэлцээнээр “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь бүртгэх үйлчилгээний хөлсийг Засгийн газрын бодлого, хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд нийцүүлж, боломжит хэмжээнд бууруулах байр суурьтай гэх”, мөн түүнчлэн “хөрөнгийн зах зээлд оролцогч компаниудын гаргасан гомдол, Санхүүгийн зохицуулах хорооны ирүүлсэн чиглэл зэргийг үндэслэн үйлчилгээний хөлсийг өөрчлөн тогтоосон” гэсэн тайлбаруудаас мөн л хамтын сангийн нэгж эрхийн бүртгэх үйлчилгээний хөлсийг бууруулж тогтоосон захиргааны актын зорилго тодорхойлогдож байна.

3.6.Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т Захиргааны үйл ажиллагаанд дараах тусгай зарчмыг баримтална” гээд мөн зүйлийн 4.2.4-т “үр нөлөөтэй байх” мөн зүйлийн 4.2.5-т “зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх” гэж заасан байна.

3.7.Иймд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь хамтын сангийн нэгж эрхийн бүртгэх үйлчилгээний хөлсийг бууруулж шинээр тогтоож гаргасан актын зорилго нь хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагуудын санал, хүсэлтэд үндэслэсэн, уг зах зээлийн хөгжлийг түргэтгэх шаардлага үүссэн, зах зээлд оролцогч компаниудын хөгжилд нөлөөлж байгааг өөрчлөхөд чиглэсэн тул актыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь энэ зорилгод нийцсэн байх ёстой гэж шүүх үзлээ.

3.8.Энэ учраас хариуцагч “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2018/07 дугаартай тогтоолоор баталсан үйлчилгээний хөлс мөрдөгдөж байх үед ”Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан”

ХХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэгдсэн учраас, тухайн үед хүчинтэй байсан журмын дагуу бүртгэлийн хураамж төлнө” гэх үндэслэлээр **“нэхэмжлэгчийг шинээр бууруулж тогтоосон хувь хэмжээгээр үйлчилгээний хураамж төлүүлэхээс татгалзсан”** шийдвэрийг Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-т “үр нөлөөтэй байх” мөн зүйлийн 4.2.5-т “зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх” гэсэнд нийцээгүй, хууль бус гэж үзсэн.

3.9.Нөгөө талаас нэхэмжлэгч “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс нь өөрийн компанийн үйл ажиллагааг доголдолд оруулахуйц хэт өндөр хэмжээтэй тогтоосон гэж үзэн эс зөвшөөрч маргаж байсан бөгөөд түүний энэ байдлыг дээрдүүлсэн үйлчилгээний хөлсийг шинээр тогтоосон нь эрх зүйн харилцаанд “иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх” зарчим үйлчилнэ гэж үзлээ.

3.10.Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь шүүхэд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргаж, үүгээрээ компани алдагдалтай ажилладаг учраас үйлчилгээний хураамжийн 1 хувиар тогтоосон гэдгээ нотолж мэтгэлцсэн.

3.11.Засгийн газраас үнэт цаасны зах зээлд зохицуулалт, тохируулга хийж оролцохоор өөрийн хөрөнгөөр компани байгуулчхаад түүнийгээ алдагдалтай ажиллаж байна гэж үзэн уг зах зээлд оролцогч, үүний дотор шинээр байгуулагдсан компаниудын бүртгүүлсэн нийт хөрөнгийн 1 хувийг бүртгэлийн хөлс болгож хураахаар журам тогтоож, үүний үр дагавар нь компанийн хөрөнгөөс 500 гаруй сая төгрөгийн зардал учруулахаар байгаа нь зүй ёсны харилцаа биш юм.

3.12.Түүнчлэн нэхэмжлэгчээс “бүртгүүлсэн нийт хөрөнгийн 1 хувийг төлөх”-өөр тогтоосон журмыг үндэслэлгүй тогтоосон гэж шүүхэд маргасан, уг маргааны явцад хариуцагч тогтоосон хэмжээгээ бууруулсан атлаа “өмнөх журам хүчин төгөлдөр байхад гэрээ байгуулсан, гэрээний үнийг зөвшөөрч байгуулсан тул гэрээний дагуу төлөх ёстой гэснийг шүүх хүлээн аваахгүй юм.

3.13.Дээр дурдсанаар нэхэмжлэгч нь анхнаасаа нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс- Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс 1% гэдгийг эс зөвшөөрч шүүхэд нэхэмжлэл гаргасан нь нотлогдож байгаа ба хариуцагчаас үйлчилгээний хөлсийг компанид хохиролтой гэж үзэн бууруулсан байхад тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байсан журмыг баримтална, гэрээгээр үнийг зөвшөөрсөн гэж үзэн өмнөх үнээр төлүүлэх нь шударга ёсонд нийцэхгүй гэж үзлээ.

3.14.Дээрх хууль зүйн үндэслэл болон эрх зүйн зарчмыг баримтлан нэхэмжлэгч “Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж буюу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2-т заасан хувиар тус компанийн бүртгэлийн үйлчилгээний хөлс хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгах шаардлагыг хангаж шийдвэрлэв.

Дөрөв. Анхан шатны шүүхэд нотлох баримт цуглуулсан, үнэлсэн талаар:

4.1.Шүүх нь хуульд заасан журмыг үндэслэн хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд дүгнэлт хийж, маргааныг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн ба нотлох баримтыг хэрхэн үнэлэх, үнэлэхгүй байх нь хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шүүгчийн дотоод итгэл, эрх хэмжээнд хамаарах болно.

4.2.Анхан шатны шүүх нь энэхүү хэрэгт Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн 221/2022/0003/3 индекстэй хэргийг бүхэлд нь татан авч, уг хэрэгт авагдсан нотлох баримт болон шүүхийн ажиллагаатай холбоотой баримтыг шинжлэн судалж дүгнэлт хийсэн болно.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3.12 дахь заалтад тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4, 4.2.5, 4.2.8-д заасныг баримтлан нэхэмжлэгч "Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан "Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2-т заасан хувиар "Мандал ирээдүй өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-иас бүртгэлийн үйлчилгээний хөлс хураахыг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д даалгасугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д заасныг баримтлан, нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70,200 төгрөгийг хариуцагчаар нөхөн гаргуулж, нэхэмжлэгчид олгосугай.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1 дэх хэсэгт зааснаар хэргийн оролцогчид, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нь шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах журмаар гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2023 оны 4 сарын 13 өдөр

Дугаар 201/МА 2023/0252

Улаанбаатар хот

“Мандал ирээдүйн өсөлт
хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн
нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн давж заалдах журмаар хэргийг шийдвэрлэсэн

Шүүх бүрэлдэхүүн:

Шүүх хуралдаан даргалагч шүүгч О.Оюунгэрэл,
Бүрэлдэхүүнд оролцсон шүүгч Д.Оюумаа,
Илтгэсэн шүүгч Г.Мөнхтулга,

Давж заалдах гомдол гаргасан хэргийн оролцогч:

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ,

Хэргийн оролцогчид:

Нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан”

ХХК

Хариуцагч “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК,

Нэхэмжлэлийн шаардлага: “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг хариуцагчид даалгах,

Давж заалдах гомдол гаргасан шүүхийн шийдвэр: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 92 дугаар шийдвэр,

Давж заалдах шатны шүүх хуралдааны оролцогчид:
Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайхан, өмгөөлөгч Ю.Тогмид,
хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрахбаяр нар,

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Улаанмуна.

Хэргийн индекс: 128/2022/0888/3.

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-нд холбогдуулан “Мандал ирээдүйн өсөлт

221011697

хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг хариуцагчид даалгах”-аар маргасан.

2. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 92 дугаар шийдвэрээр “Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4, 4.2.5, 4.2.8-д заасныг баримтлан нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж, баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2-т заасан хувиар “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-иас бүртгэлийн үйлчилгээний хөлс хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгаж” шийдвэрлэсэн.

3. Давж заалдах гомдлын агуулга: Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч дараах үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргасан. Үүнд:

3.1 Нэхэмжлэгч урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагааг зохих журмын дагуу хийгээгүй байхад нэхэмжлэлийг хүлээн авч хэргийг шийдвэрлэсэн нь буруу,

3.2 Нэхэмжлэгч хариуцагчийн хооронд гэрээний харилцаа байхад үүнд дүгнэлт өгөөгүй,

3.3 Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг буруу тайлбарлан хэрэглэсэн зэрэг үндэслэлээр тайлбарлаж байна.

4. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчийн зүгээс хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг үгүйсгэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хамгаалж байна.

ХЯНАВАЛ:

1. Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн байх тул шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэв.

2. Нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д холбогдуулан “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргасан.

3. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчөөс нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь үйлчилгээний хураамжийг 1%-иар тогтоосон нь эдийн засгийн тооцоо судалгаа үндэслэлгүй, хөрөнгийн зах зээлд оролцогч компанийг эдийн засгийн хувьд илт хохироосон, алдагдалд хүргэж болзошгүй, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд Монголын хөрөнгийн биржийн 2019/07 дугаар тогтоолоор баталсан журамтай холбогдуулан маргаж байх явцад хариуцагч 2021 оны 16 дугаар тогтоолоор үйлчилгээний хураамжийг багасгаж өөрчилж баталсан нь дээрх нөхцөл байдлыг

хариуцагч өөрөө хүлээн зөвшөөрсөн нь харагдаж байдаг. Улмаар бид шинэчлэн баталсан журмын дагуу үйлчилгээний хураамжаа төлөх байх гэж найдан давж заалдах шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан боловч хариуцагч тэгээгүй” гэсэн агуулгаар тайлбарлан маргажээ.

4. Анхан шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн тодруулж, тус шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан мөн эсэхэд дүгнэлт хийлгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрсөн байх тул давж заалдах шатны шүүх маргааны үйл баримтад дүгнэлт өгч, хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй байна.

4.1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “...тус хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 52 дугаар зүйлийн 52.5.1-д “...эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, захиргааны акт гаргуулахыг даалгах нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн”, 106 дугаар зүйлийн 106.3.4-т “захиргааны актыг гаргахаас татгалзсан шийдвэр, эсхүл гаргахгүй байгаа эс үйлдэхүй нь хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн бол шаардагдах захиргааны акт гаргахыг тухайн захиргааны байгууллагад даалгах, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоох” гэж тус тус заасанчлан анхан шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн тодруулж, нэхэмжлэгчийн хүсэж буй эрх зүйн хамгаалалт нь хуулиар тухайн нэхэмжлэлийн төрөлд тавигдах урьдчилсан нөхцөлийг хангаж байх тохиолдолд хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах үүрэгтэй.

4.2. Тухайн тохиолдолд, нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК нь хариуцагч “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-тай 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдөр 2021/72 дугаар “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн гэрээ” байгуулсан. Гэрээний 2.1.2-т “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2019 оны 2019/07 дугаар тогтоолоор батлагдсан Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6.2.2-т заасанчлан “нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс – нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь” тусгасан. Улмаар, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6.2.2 дахь заалтыг “нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс - Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч: 6.2.2.1 20 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.5%, 6.2.2.2 20-50 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.375%, 6.2.2.3 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд 0.25% тус тус байх ба хамгийн багадаа 25,000,000 төгрөг, хамгийн ихдээ 150,000,000 төгрөг” байхаар өөрчлөн тогтоосонтой холбогдуулан нэхэмжлэгчээс 2021 оны 2021/72 дугаар “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн гэрээ”-ний нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор өөрчлөлт тогтоосон хувиар хураахыг хариуцагчид даалгах нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан байна.

4.3. Тус үйл баримттай холбогдуулан анхан шатны шүүх, нэхэмжлэгчийн эрхийн хамгаалалт хүсэн маргаж буй эрх, ашиг сонирхол нь захиргааны хэргийн шүүхээр хамгаалагдах эрх, ашиг сонирхол мөн эсэх, хэрэв мөн бол дан ганц даалгах нэхэмжлэлийн шаардлагаар шүүх захиргааны хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах хууль, эрх зүйн боломжтой эсэх асуудлыг тодруулж, тухайн

асуудалд хууль зүйн дүгнэлт хийсний үндсэн дээр хэргийг шийдвэрлэх нь зүйтэй байна.

5. Иймд, анхан шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага, түүний хууль зүйн үндэслэлийг бүрэн тодруулаагүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын зөрчил гаргасныг давж заалдах шатны шүүхээс залруулан хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Мөн 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн шүүх хуралдааны тэмдэглэл нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “нотлох баримт нь ... шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно”, 88 дугаар зүйлийн 88.3-т “Шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш ... тэмдэглэлийг бэлэн болгох ба түүнд шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна” гэх хуулийн шаардлагыг хангахгүй байгааг дурдах нь зүйтэй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 121 дүгээр зүйлийн 121.1.4, 121.3.3, 121.3.4-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 92 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд буцаасугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-д заасныг баримтлан нэхэмжлэгчийн давж заалдах гомдол гаргахдаа төлсөн 70200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэж хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

ШҮҮГЧ

ШҮҮГЧ



О.ОЮУНГЭРЭЛ

Д.ОЮУМАА

Г.МӨНХТУЛГА



**НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ
ШИЙДВЭР**

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 128/ШШ2023/0757

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨЭС

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Ц.Мөнхзул даргалж, шүүгч Л.Батбаатар, шүүгч Д.Чанцалням нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн шүүх хуралдааны "1" дүгээр танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар,

Нэхэмжлэгч: "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК, /РД:6702988/,

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Я.Баярсайхан,

Хариуцагч: "Монголын хөрөнгийн бирж" ХК,

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: П.Ундрах-Эрдэнэ нарын хоорондын хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журамд заасан үйлчилгээний хөлстэй холбоотой маргааныг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайхан, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ, иргэдийн төлөөлөгч Ү.Уранцэцэг, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга П.Энхжаргал нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг. Маргааны үйл баримтын талаар:

1.1 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК/хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсан/-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг баталсан байх ба тус журмын 6.2.2-т "Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%" гэж зохицуулжээ.

1.2. "Мандал ирээдүйн өсөлт хамтын Хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 22/069 тоот албан бичгээр, "Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт мөн оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 22/80 тоот албан бичгүүдээр үйлчилгээний хураамжийг хэт өндөр тогтоосныг багасгах талаар тус тус хүсэлт гаргасан.

1.3. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/4258 тоот албан бичгээр "Монголын хөрөнгийн бирж" ХК-д "... хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг хэт өндрөөр буюу 1 хувиар тогтоосон нь бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад 10 дахин их байх бөгөөд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо өсөхгүй байх, зах зээлд оролцогч, хөрөнгө оруулагчдын идэвх сонирхол буурах, улмаар хувийн хэвшлээс нийтэд санал болгосон үнэт цаас гаргахтай холбоотой зардал, өртгийг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. ... иймд үйлчилгээний хөлсний хэмжээг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан бууруулах арга хэмжээг зохион байгуулах"-ыг чиглэл болгосон.

140104196

1.4. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор батлагдсан журамд нэмэлт өөрчлөлт оруулсан ба тус тогтоолын 1 дэх хэсгийн 1-д “Журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1% гэснийг “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч: 6.2.2.1 20 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.5%, 6.2.2.2 20-50 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.375%, 6.2.2.3 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд 0.25%” гэж өөрчилсөн.

1.5. 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-иас “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2. Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1% гэснийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан.

1.6. Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 20 дугаартай захирамжаар “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасныг үндэслэн “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-аас “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д холбогдуулан гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д холбогдох, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтын “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6.2.2-т “нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь гэснийг хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэлээсээ нэхэмжлэгч татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэж шийдвэрлэсэн.

1.7. “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас 2021 оны 08 дугаар сарын 11, 2022 оны 09 дүгээр сарын 22, мөн оны 12 дугаар сарын 26-ны өдрүүдэд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсний үлдэгдэл 450,000,000 төгрөгийг төлөх нэхэмжлэхүүдийг “Мандал ирээдүйн өсөлт хөрөнгө оруулалтын сан” ХХК-д хүргүүлсэн.

1.8. 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д даалгах” шаардлага бүхий нэхэмжлэл гаргаж, 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдөр нэхэмжлэлийн шаардлагаа “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус болохыг тогтоолгох” гэж нэмэгдүүлсэн.

Хоёр. Нэхэмжлэлийн үндэслэл:

2.1 Нэхэмжлэгчээс шүүхэд ирүүлсэн нэхэмжлэлдээ:

“Нэг. Урьдчилсан шийдвэрлэх журам биелүүлсэн тухайд:

Манай компани нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулахаар Компанийн тухай хуульд заасан журмын дагуу 2021 оны 08 дугаар сарын 28-ны өдөр үүсгэн байгуулагдаж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд

заасан журмын дагуу бүртгэл хийлгэх, зохих баримт бичгийг бүрдүүлэх зорилгоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас гаргасан дүрэм, журмуудтай танилцаж, анх бүртгүүлэхээр тус байгууллагад хандсан болно. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг баталж, уг журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтаар “нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсийг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%” байхаар журамлан тогтоожээ.

Энэхүү журамд үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд нь сангийн нэгж эрхийг бүртгүүлэхдээ нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувийг үйлчилгээний хөлсөнд төлөхөөр хатуу тогтоосон нь илт эдийн засгийн үндэслэлгүй гэж үзэж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.18-д “үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санал болгох, энэ саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох, энэ тухайгаа нийтэд мэдээлэх”, 74 дүгээр зүйлийн 74.4-т “Хороо хууль тогтоомжтой зөрчилдсөн дүрэм, журмыг бүхэлд нь, эсхүл тэдгээрийн зарим заалтыг өөрчлөх даалгавар өгч болно”, 75 дугаар зүйлийн 75.2-т “Өөрийгөө зохицуулах байгууллагын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд Хороо шалгалт хийнэ”, мөн зүйлийн 75.4-т “Өөрийгөө зохицуулах байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн нь энэ хууль, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд Хороо дараах арга хэмжээ авч, нийтэд мэдээлнэ”, мөн зүйлийн 75.4.2-т “даалгавар өгөх” гэж тус тус заасныг үндэслэн “нэгж эрхийн үнийг бүртгүүлэх үйлчилгээний хөлс 1 хувь байхаар журамласан заалтыг эс зөвшөөрч, уг хувь хэмжээнд өөрчлөлт оруулах тухай хүсэлтээ эрх ашгаа хамгаалуулахаар нэгдэж, гишүүн нь болсон “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” төрийн бус байгууллагаар дамжуулан Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан, СЗХ-ны дарга Д.Баярсайхан нарын нэр дээр 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 116 тоот албан бичгээр, Монголын Хөрөнгийн бирж-д 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 118 тоотоор, манай хөрөнгө оруулалтын менежментийн компани болох “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-иар дамжуулан 2021 оны 06 дугаар сарын 16-ны 21/015, 8 дугаар сарын 16-ны өдрийн 21/069, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Сүх-Очирт 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 21/140 тоот албан бичгүүдээр удаа дараа хүсэлт гаргасны дагуу Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-иас 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/465 тоот хариу хүргүүлэх тухай албан бичгээр ирүүлсэн хариуг эс зөвшөөрч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.1.1, 14.2-т заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Шүүгчийн 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2030 дугаартай “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай” захирамжийн дагуу “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС”-аас 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 21/203 тоот албан бичгээр Үйлчилгээний хураамжийг хүчингүй болгуулах талаар хандахад Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/4258 тоот албан бичгээр “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаатай чиглэл өгсөн боловч хэрэгжүүлээгүй тул Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтын “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2. “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%” гэснийг хүчингүй болгуулахаар

нэхэмжлэлийн шаардлага гаргасныг шүүх хүлээн авч, Захиргааны хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх хугацаанд "Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 зүйлийн 6.2.2 дахь заалтад 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор:

1. Журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт "нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь" гэснийг Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч:

6.2.2.1. 20 тэрбум хүртэлх үнийн дүнд - 0.5 хувь,

6.2.2.2. 20 - 50 тэрбум хүртэлх үнийн дүнд - 0.375 хувь,

6.2.2.3. 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд - 0.25 хувь гэж өөрчлөлт оруулан Санхүүгийн Зохицуулах Хороогоор баталгаажуулсан тул нэхэмжлэлийн шаардлага хангагдсан гэж үзэж нэхэмжлэлээсээ татгалзах тухай хүсэлтээ шүүхэд гаргасны дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 20 дугаартай "Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" захирамж гарсан.

"Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн зүгээс "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 зүйлийн 6.2.2 дахь заалтад 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор:

1. Журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт "нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь" гэснийг Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс - Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч:

6.2.2.1. 20 тэрбум хүртэлх үнийн дүнд - 0.5 хувь,

6.2.2.2. 20 - 50 тэрбум хүртэлх үнийн дүнд - 0.375 хувь,

6.2.2.3. 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд - 0.25 хувь гэж өөрчлөлт орсон тул дээрх өөрчлөлт орсон журмын заалтын дагуу нэгж эрхийн бүртгэлийн хөлсийг төлөх тухай хүсэлтийг ... оны ... сарын ..-ны өдрийн ... тоот албан бичгээр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 22/069 тоот албан бичгээр гаргасан боловч хариу мэдэгдэлгүй эс үйлдэхүй гаргасан тул энэхүү нэхэмжлэлийн шаардлагыг гаргаж байна.

Хоёр. Энэхүү маргаан нь захиргааны шүүхийн харьяаллын болох тухайд:

Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно" гээд мөн зүйлийн 5.1.4-т "үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа" гэж тус тус заасан байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж, 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулиар үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, арилжих, бүртгэх, төлбөр, тооцоог гүйцэтгэх, хадгалах, бусад зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна" гэж, мөн зүйлийн 3.4-т "Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, ... зохицуулна" гэж заасан байна.

Эдгээр заалтуудаас үзвэл үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогч олон нийтэд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нийтлэг үйлчилгээ үзүүлдэг, нийтээс тус компанийн үйлчилгээг нь авдаг гэдгийг тодорхойлсон байна.

Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 1.2-д "Энэхүү журмыг Биржийн нэгж эрхийн бүртгэлд бүртгэгдсэн,

бүртгүүлэхээр хүсэлт гаргасан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан, түүнийг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон бусад эрх бүхий албан тушаалтан, аудитор, хуульч, хөрөнгийн үнэлгээчин болон холбоотой бусад этгээд дагаж мөрдөнө" гэж заасан нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт болохыг тогтоосон байна. Иймд нэхэмжлэгчээс энэхүү хэм хэмжээ тогтоосон журам нь захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх захиргааны акт мөн гэж үзсэн болно.

Гурав. Нэхэмжлэлийн үндэслэлийн тухайд:

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т "Энэ хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлийн тогтолцооны эрсдэлийг бууруулах, шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах зарчмыг баримтална" гэж заасан байна. Хуулийн энэ заалт нь үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн тогтолцоог эрсдэлгүй байлгах, үр ашигтай байлгах үзэл санаа /концепци/-г зарчим болгон тогтоосон болно.

Монгол Улс нь 1991 онд улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулснаар хөрөнгийн зах зээлийн эхлэл тавигдсан ба энэхүү харилцаа манай улсын хувьд хөгжлийнхөө дөнгөж эхлэл шат буюу 30 дахь жилд яваа бөгөөд 2017 оноос хойш хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд оролцох ойлголт сайжирч, идэвх нь нэмэгдэх хандлагатай болсон. "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан хамгийн том хөрөнгө оруулалтын сан гэж одоогоор тооцогдож байна.

Хөрөнгийн зах зээл үүсгэн байгуулагдсанаас хойш одоог хүртэл хөрөнгийн зах зээл дэх бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн зөв зохистой харьцаа бүрэлдэхгүй байсаар ирсэн бөгөөд энэ салбарын зохицуулалт одоогоор хангалттай төлөвшөөгүй байгаа тул төрийн зохицуулалт шаардлагатай, төрөөс дэмжлэг үзүүлэх салбар мөн билээ. Ийм ч учраас хууль тогтоогч нараас Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т "Хөрөнгийн бирж үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй" байхаар хуульчлан тогтоож өгсөн байна.

Дээрх хуулийн заалтаар Хөрөнгийн биржид үйлчилгээний хөлс тогтоох эрхийг олгосон боловч тус байгууллага нь энэхүү эрхийг аливаа хязгааргүйгээр эдлэх ёстой гэсэн ойлголт огт биш гэдэг нь мөн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан үзэл баримтлалаас харагдах болно.

Энэ ч учраас "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1 дүгээр хавсралтаар хувьцаа болон бонд бүртгүүлэхэд төлөх бүртгэлийн үйлчилгээний хөлсийг 0,1 хувь, нийтдээ 50,000,000 төгрөгөөс ихгүй байхаар "анх тогтоосон" байдаг.

Энэхүү журам нь Үнэт цаас гаргагчийн анх удаа болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгслийг Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой журам юм.

Хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь тодорхой хууль зүйн болон бусад эдийн засаг, санхүүгийн үндэслэл, шаардлага шалтгаангүйгээр 2019 онд "Хамтын хаалттай Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг шинээр батлахдаа сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хураамжийг 1 хувь болгож нэмэгдүүлснээр өөрийн хуульд заасан эрхээ эдэлж байгаа мэт боловч эдийн засгийн тооцоо, судалгаа, үндэслэлгүйгээр үйлчилгээний хөлсийг нэмж

тогтоосноор хөрөнгийн зах зээлд оролцогч компанийг эдийн засгийн хувьд илт хохироосон, алдагдалд хүргэж болзошгүй зохицуулалт болсон.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд "Үнэт цаас" гэдэгт дараах санхүүгийн хэрэгсэл хамаарахаар заасан. Үүнд:

1. хувьцаат компанийн хувьцаа /цаашид "хувьцаа" гэх/;
2. компанийн өрийн хэрэгсэл;
3. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
4. хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх;
5. хадгаламжийн бичиг;
6. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;

7. үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх /варрант/;

8. үүсмэл санхүүгийн хэрэгсэл зэрэг байхаар заасан.

Гэтэл МХБ нь хувьцаа ба бондын хураамжийг 0,1 хувь буюу 50 сая төгрөгөөс хэтрэхгүй гэж тогтоосон боловч сангийн нэгж эрхийг 1 хувь байхаар тогтоосон нь шударга бус байсан ба хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндөж, хохироох нөхцөлд хүргэсэн. Хувьцаа, бонд, сангийн нэгж эрх болон аливаа үнэт цаасыг бүртгэх үйлчилгээ нь үнийн дүнгээс үл хамаарсан нэг л үйл ажиллагаа бөгөөд түүнийг бүртгэж, материал бүрдүүлэх зэрэг цөөн хэдхэн ажиллагаа явагддаг юм. МХБ нь ийм буруу журам гаргаснаа хүлээн зөвшөөрсөн нь сая журмаа өөрчилснөөр нотлогдоно.

Манай хөрөнгө оруулалтын сан нь 7,000 орчим нэгж эрх эзэмшигчтэй ба эдгээр иргэдээс санд төвлөрүүлсэн 50,000,000,000 /Тавин тэрбум/ төгрөгөөс арилжааны шимтгэл хэлбэрээр 376,000,000 төгрөгийг төлсөн бөгөөд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2-д заасан нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсийг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1% гэсэн заалтын дагуу нэгж эрх бүртгүүлэхэд төлөх хураамж 500,000,000 төгрөгийг нэмж төлсөн тохиолдолд нийт иргэдийн төвлөрүүлсэн сангийн хөрөнгөөс 876 сая төгрөгийг шууд төлбөр хураамж нэрээр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК суутган авч санг эхнээс нь алдагдалд хүргэх сөрөг үр дагавартай тул дээрх журмын заалтыг эс зөвшөөрч хүчингүй болгуулахаар "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар нэхэмжлэлийн шаардлага гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх хугацаанд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт бүхэлд нь өөрчлөлт оруулан одоо мөрдөж ажиллаж байна.

Манай компанийн зүгээс шинээр мөрдөгдөж байгаа 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өөрчлөлт орсон дээрх журмын заалтын дагуу нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс төлөх талаар "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д удаа дараа хүсэлт гаргасан боловч хүсэлтийг хүлээн авалгүйгээр илт шударга бус, хэт өндөр үнэ бүхий 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 тогтоолын хавсралтад зааснаар хөлс төлөхийг шаардаж байгаа нь үндэслэлгүй гэж үзэж байна.

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-н Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтын "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын Зургаа дугаар зүйлийн 6.2.2. Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1% гэсэн журмын заалтын дагуу үйлчилгээний хөлс төлсөн тохиолдолд нэгж эрх эзэмшигч хөрөнгө оруулагч 7000 орчим иргэний эрх ашигт сөргөөр

нөлөөлж, хөрөнгийн зах зээлийн харилцаанд шууд оролцогч манай компанийг эдийн засгийн хувьд алдагдалд оруулж болзошгүй юм.

Дээрх үндэслэлээр "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн үйлчилгээний хөлсийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг "Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК-д даалгуулахаар энэхүү нэхэмжлэлийн шаардлагыг гаргаж байна" гэв.

2.2. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайхан шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

"Нэхэмжлэгч компани нь 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр тус шүүхэд нэхэмжлэлийн шаардлага гаргасан. Анхны нэхэмжлэлийн шаардлага бол Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-ийн эрхийн бүртгэлийн хураамжийг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан. Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн Нэгж эрхийн бүртгэлийн хураамжийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс гарахыг Монголын хөрөнгийн бирж хувьцаат компанид даалгах шаардлага гаргасан. Энэ шаардлагын дагуу анхан шатны шүүхээс хэлэлцээд хариуцагчийн гаргасан гомдлын дагуу давж заалдах шатны шүүхээр хэлэлцээд хүчингүй болж шийдвэрлэсэн. Үүний дараа магадлалд дурдсанаар Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-иас нэхэмжлэлийн шаардлагаа дараах байдлаар тодруулсан.

Үүнд Монголын хөрөнгийн бирж төрийн өмчид хувьцаат компанийн ТУЗ-ийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийг хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох. Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-ийн нэгж эрхийн хураамжийг Монголын хөрөнгийн бирж төрийн өмчид хувьцаат компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан. Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүх төрлийн хураамжийн төслүүдийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан журмаар хураахыг Монголын хөрөнгийн бирж компанид даалгуулахаар нэхэмжлэлийн шаардлага тодруулсан. Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл бол маргаж байгаа хураамжийн хувь хэмжээ хэт өндөр байгаа болон давамгай байдалтай хуулийн этгээд болох Монголын хөрөнгийн бирж компанитай гэрээ байгуулахаас өөр хохирол байгаагүй талаар анх гарсан нэхэмжлэлийн шаардлагад тодорхой дурдсан. Тухайн үед Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг хөрөнгө оруулалтын сангийн нийт эрхийг бүртгэх хуулиар эрх олгож үйл ажиллагаагаа явуулж байсан аж ахуйн нэгж нь монголын хөрөнгийн бирж давамгай эрх бүхий хувьцаат компани байсан. Бидний зүгээс тухайн зөрчлийг зөвшөөрч бүртгэх үйл ажиллагаа явуулах ямар нэгэн боломж байхгүй учраас ингэж бүртгүүлсэн.

Нэгж эрхийг бүртгүүлсний дараагаар бүртгэлийн үйлчилгээний хураамж нь 500 сая төгрөг болсон нь хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг доголдуулж хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироох магадлалтай байсан тул 2021 оны 9 дүгээр сараас эхлэн өнөөдөр хүртэл хугацаанд захиргааны хэргийн шат шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж шүүхээр шийдвэрлэж байна. Энэхүү журам үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахыг үүсгэн байгуулсан хуулийн этгээд нь сангийн

нэгжих эрхийг бүртгүүлэхдээ нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн нэг хувийг үйлчилгээний үндсэн нэг тохиолдолд төлөхөөр хатуу тогтоосон эдийн засгийн үндэслэлгүй гэж үзсэн. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т энэ хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлийн тогтолцооны эрсдэлийг бууруулах, шударга, ил тод байдлыг хангах зарчмыг баримтлан гэж заасан. Хуулийн энэ заалт нь үнэт цаас хөрөнгийн зах зээлийн тогтолцоог өрсөлдөхгүй, өөрчлөлтгүй байлгах санаа нь концессын зарчимд тогтсон байдаг. Энэ жагсаалтад Монголын хөрөнгийн бирж хувьцаат компани 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 дугаартай тогтоолоор баталсан Үнэт цаасны нөхцөлийн журмын 1 дүгээр хавсралтаар хувьцаа болон бонд бүрдүүлэхэд төлөх бүртгэлийн үйлчилгээний хөлс төлсөн 0,1% хувь нийтдээ 50 саяаас ихгүй байхаар авагдсан байдаг.

Гэтэл Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь хувьцаа болон бондын хураамжийг 0,1% буюу 50 сая төгрөгөөс хэтрэхгүй гэж тогтоосон боловч сангийн нэгж эрхээ нэг хувь гэж дээшээ лимитгүй тогтоосон нь үндэслэл бүхий биш гэж үзэж байна. Үнэт цаасны тухай хуульд хувьцаа, бонд, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүгдийг нь үнэт цаас гэж үзнэ гэж заасан. Энэхүү журам нь үнэт цаас гаргагчийн анх удаа болон нэмж гаргасан хувьцаа өөрийн хэрэгслийг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зааглаж зохицуулах журам юм. Хариуцагч компани нь хууль зүйн болон бусад эдийн засаг, санхүүгийн үндэслэл, шаардлага, шалтгаангүйгээр 2019 онд хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгжийн журмыг шинээр батлахдаа сангийн нэгж эрх бүртгэх бүртгэлийн хураамжийг нэг хувь болгож нэмэгдүүлснээр өөрийн хуульд заасан эрхээ эдэлж байгаа мэт боловч эдийн засгийн тооцоо судалгааг үндэслэлгүйгээр үйлчилгээний хөлсийг нэмж тогтоосноор хөрөнгийн зах зээлд оролцож компанийг эдийн засгийн хувьд илт хохироосон гэсэн алдагдал төөрөгдөлд оруулж болзошгүй зохицуулалт болсон.

Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК нь 7 мянга орчмын нэгж эрх эзэмшигчтэй ба эдгээр иргэдээс 50 тэрбум төгрөгөөс арилжааны шимтгэл хэлбэрээр 376 сая төгрөгийг төлсөн бөгөөд Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6 дахь 2.2-т заасан нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсийг бүртгүүлсэн үнийн дүнгийн нэг хувь гэсэн заалтын дагуу нэгж эрх бүртгүүлэхэд төлөх хураамж 500 сая төгрөгийг нэмж төлсөн тохиолдолд нийт иргэдийн төвлөрүүлсэн сангийн хөрөнгөөс 876 сая төгрөгийн шууд төлбөр хураамж нэрээр Монголын хөрөнгийн бирж суутган авах сөрөг үр дагавартай тул дээрх журмын заалтыг эс зөвшөөрч хүчингүй болгуулахаар Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар нэхэмжлэлийн шаардлага гаргана хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Монголын хөрөнгийн бирж ХК журмын 6.2.2 дахь хэсэгт бүхэлд нь өөрчлөлт оруулж ажиллаж байгаа.

Манай компанийн зүгээс шинээр бүрэлдэж байгаа 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өөрчлөлт орсон дээрх журмын заалтын дагуу үйлчилгээний хөлсийг төлөх талаар Монголын хөрөнгийн бирж компанид удаа дараа хүсэлт гаргасан боловч хүсэлтийг хүлээж авалгүйгээр илт шударга бус Монголын хөрөнгийн бирж компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт орж хүчингүй болсон 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2010/07 дугаартай тогтоолын хавсралтаар баталсан хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь

хэсэгт зааснаар үйлчилгээний хөлс шаардаж байгаа нь илт хууль бус юм. Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-ийн 2022 оны 9 дүгээр сард Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатын шүүхэд нэхэмжлэл гаргаж захиргааны ажиллагаа явагдаж байх хугацаанд Монгол улсын их хурлаас Захиргааны ерөнхий хуулийн 60.4 дэх хэсэгт хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд захиргааны хэмжээний актыг буцаан хэрэглэхгүй гэсэн нэмэлт өөрчлөлтийг 2022 оны хуулиар оруулсан тул энд заасны дагуу хүчингүй болсон журмын холбогдох хэсгийг буцаан хэрэглэх нь хууль бус юм гэж үзэж байна. Дээрх асуудалд Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК болон Монголын хөрөнгийн хийж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар тогтоолын 2.2 дахь заалтад бүртгэлийн хураамжид нь хууль бус болохыг тогтоолгох нийт эрхийн бүртгэлийн үндэсний хөлсийг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2-т заасан хуваарь хураахыг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д даалгуулахаар нэхэмжлэлийн шаардлагыг гаргаж байна.” гэв.

Гурав. Хариуцагчийн хариу тайлбар, татгалзал:

3.1 Хариуцагчаас тус шүүхэд бичгээр ирүүлсэн тайлбартаа:

“1. Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны талаар:

“Монголын хөрөнгийн бирж” нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад заасан үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий төрийн өмчит хуулийн этгээд юм.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлд зааснаар Санхүүгийн зохицуулах хороо, түүний Маргаан таслах зөвлөл нь үнэт цаасны зах зээлд гарсан маргаантай асуудлыг тэргүүн ээлжид шийдвэрлэдэг.

Гэтэл “Мандал ирээдүйн өсөлт” ХХОС нь нэхэмжлэлд дурдсан асуудлаараа 2022 оны 08-р сарын 16-ны өдрийн дугаар 22/80 тоот албан бичгээр СЗХ-ны Үнэт цаасны газарт хандсан байна, СЗХ-ны Үнэт цаасны газар нь үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаанд төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлдэг ажлын алба бөгөөд түүнд зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэх бүрэн эрх хуулиар олгогдоогүй болно.

Иймд “Мандал ирээдүйн өсөлт” ХХОС нь “Монголын хөрөнгийн бирж”-ийн үйлчлүүлэгч, нөгөө талаар үнэт цаасны зах зээлд оролцогчийн хувьд нэхэмжлэлд дурдсан асуудлаараа хуульд заасан захиргааны урьдчилсан шийдвэрлэх ажиллагаа хийлгээгүй, маргааныг урьдчилан шийдвэрлэх эрх бүхий СЗХ-ны Маргаан таслах зөвлөлд хандаагүй байна.

2. Захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан мөн эсэх талаар:

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1-д зааснаар үнэт цаасны 17 зохицуулалттай үйл ажиллагаа байдаг. Дурдвал:

(1) Үнэт цаасны брокер, (2) диллер, (3) андеррайтер, (4) хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, (5) үнэт цаасны итгэмжлэн удирдах, (6) үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл, (7) үнэт цаасны арилжааны тооцооны, үнэт цаасны кастодианы (9) Үнэт цаасны арилжаа эрхлэх (10) үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх гэх мэт.

Дээр дурдсан 17 үйл ажиллагааг СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулах ба төрийн өмчит хуулийн этгээд эсхүл хувийн хэвшлийн

байгууллага аль аль нь эрхлэн явуулах боломжтойн зэрэгцээ үүнд өмчийн хязгаарлалт тогтоогоогүй.

Эдгээрийн зөвхөн нэг үйл ажиллагаа нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн явуулж буй үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа юм. Монгол Улсад өнөөдрийн байдлаар 2 арилжаа эрхлэх байгууллага СЗХ-оос тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК (төрийн өмчит компани)
- "Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК (хувийн хэвшлийн байгууллага)

Эндээс үзвэл Захиргааны ерөнхий хуулийн 5.1.4-т заасан "үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг" гэх захиргааны байгууллагын шинж хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувьд тогтоогдохгүй байх ба, ижил чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй өмчийн өөр хэлбэрийн бирж мөн зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байна.

Өөрөөр хэлбэл "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь хувийн эрх зүйн салбар буюу үнэт цаасны зах зээлийн харилцаанд бусад хувийн хэвшлийн зарим байгууллагатай өрсөлдөн ажилладаг байгууллага юм.

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг төрийг төлөөлж Монгол Улсын Сангийн яам хэрэгжүүлж, МХБ-ийн ТУЗ-ийг Сангийн яамнаас томилогдсон этгээдүүд хэрэгжүүлдэг.

МХБ-ийн хувьцааг төр эзэмшдэг боловч эрх зүйн байдлын хувьд нь үнэт цаасны арилжаа эрхлэгч бусад хувийн хэвшлийн байгууллагаас илүү эрх хэмжээ эдэлдэггүй ба бусад үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын адил Санхүүгийн Зохицуулах Хорооны хяналт, зохицуулалтад үйл ажиллагаагаа явуулдаг.

Төрийн өмчит "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон хувийн хэвшлийн "Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК яг адилхан эрх зүйн статустай байгууллага юм.

Төр аливаа компанийн хувьцааг эзэмшдэг байснаараа тухайн компани захиргааны байгууллага гэж тооцогдохгүй.

Жишээ татвал: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банкнууд дунд төр хувьцааг нь эзэмшдэг Төрийн банк үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Төрийн банк нь бусад хувийн хэвшлийн банкнуудын адил Монгол банкнаас тусгай зөвшөөрлөө авч, хувийн эрх зүйн харилцаанд оролцож байна. Төрийн банкнаас зээлдэгч нартаа зориулан гаргасан зээлийн журмууд нь захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулахгүй.

Түүний нэгэн адил МХБ-ээс зөвхөн өөрийн биржид бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд зориулан журам баталсан нь нийтээр дагаж мөрдөх гадагш чиглэсэн үйлчлэлгүй, дотогшоо чиглэсэн үйлчлэл бүхий акт тул захиргааны хэмжээний акт гэж тооцогдохгүй гэж үзэж байна.

Иймд хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь Захиргааны ерөнхий хуулийн 5.1.4-т заасан "үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг" гэх захиргааны байгууллага биш бөгөөд зөвхөн манай хөрөнгийн биржид бүртгүүлсэн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх "Хамтран хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгжийн эрхийн бүртгэлийн журам" нь захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх захиргааны акт биш гэж үзэж байна.

3. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн ТУЗ-өөс баталсан Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын эрх зүйн үйлчлэлийн тухайд:

Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг МХБ-ийн ТУЗ-ийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн тогтоолоор баталсан байдаг.

Тухайн журмын үйлчлэх хүрээ нь зөвхөн өөрийн биржид бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд чиглэсэн, бүх нийтээр дагаж мөрдөх гадагш чиглэсэн эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчлэхэд чиглээгүй, дотогшоо чиглэсэн үйлчлэл бүхий акт тул Монгол Улсын захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлгүй юм.

Дээр дурдсанчлан Монгол Улсын үнэт цаасны зах зээлд 17 төрлийн зохицуулалттай үйл ажиллагаа байдаг бөгөөд уг зохицуулалттай этгээдүүдийн үйл ажиллагаа буюу:

(1) Үнэт цаасны брокер, (2) диллер, (3) андеррайтер, (4) хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, (5) үнэт цаасны итгэмжлэн удирдах, (6) үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх гэх мэт эдгээр үйл ажиллагаа эрхлэгч нь бүгд өөр өөрийн харилцагч, үйлчлүүлэгч нарт чиглэсэн дотоод дүрэм журамтай.

Эдгээр байгууллагуудын дүрэм журам нь тухайн зохицуулалттай этгээдийн зөвхөн өөрийнх нь харилцагч үйлчлүүлэгчийн хүрээнд мөрдөгдөх дотогшоо чиглэсэн үйлчлэл бүхий хэм хэмжээний акт тул Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлгүй байдаг.

4. Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журамд заасан бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооноос хянаж батламжилсан талаар:

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.3 дахь хэсэгт "Хөрөнгийн бирж үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй" гэж заасан. Үүний дагуу МХБ-ийн ТУЗ-ийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн тогтоолоор Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг батлахдаа бүртгэх үйлчилгээний хөлсийг 1 хувиар тогтоож, журмыг СЗХ-нд хүргүүлсэн байдаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 62.1 дэх хэсэгт зааснаар "Үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага" нь СЗХ бөгөөд мөн хуулийн 49.1.4-д СЗХ нь МХБ-ын дүрэм, журмыг батламжлахаар заасны дагуу СЗХ уг журмыг хүлээн авч, батламжилсан болно.

Үүнээс үзвэл нэхэмжлэгч "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэхэмжлэлийн үндэслэлдээ хариуцагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь үйлчилгээний хөлс тогтоох эрхээ хязгаарлалтгүйгээр эдэлж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т "Энэ хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлийн тогтолцооны эрсдэлийг бууруулах, шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах зарчмыг баримтална" гэж заасныг баримтлалгүйгээр сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хураамжийг 1%-иар тогтоосон гэж тайлбарласан нь үндэслэлгүй байна.

5. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн ТУЗ-өөс баталсан Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын өөрчлөлтийн талаар:

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь бүртгэх үйлчилгээний хөлсийг Засгийн газрын бодлого, хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд нийцүүлж боломжит хэмжээнд бууруулах байр суурьтай байдаг бөгөөд ийм ч үүднээс "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, гүйцэтгэх удирдлагын зүгээс үйлчилгээний хөлсний хувь хэмжээг бууруулах асуудлыг эрх бүхий субъект болох ТУЗ-д удаа дараа оруулж хэлэлцүүлж байсан болно.

Үүний дагуу Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт "нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1% байна" гэж заасан хувь хэмжээг дараах байдлаар бууруулан МХБ-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан болно. Үүнд:

Тус журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дах хэсэг “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч, 20 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.5%, 20-50 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.375%, 50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд 0.25%” тус тус байх ба хамгийн багадаа 25,000,000 төгрөг, хамгийн ихдээ 150,000,000 төгрөг байхаар нэгж бүртгэлийн үйлчилгээний хөлс өөрчлөгдсөн.

6. “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-тай үүсгэсэн харилцаа, гэрээний талаар:

“Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-тай 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр бүртгэлийн гэрээ байгуулж, тус биржийн бүртгэлд бүртгэгдсэн.

Өөрөөр хэлбэл “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаартай тогтоолоор батлагдсан үйлчилгээний хөлс мөрдөгдөж байх үед МХБ-д бүртгэгдсэн, бүртгэлийн гэрээ байгуулсан тул тухайн үед хүчинтэй байсан журмын дагуу бүртгэлийн үйлчилгээний хөлсийг тооцон төлөх үндэслэлтэй юм. Түүнчлэн талуудын хооронд байгуулагдсан бүртгэлийн гэрээний 2.1.2-т зааснаар бүртгэх үйлчилгээний хөлсийг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувиар тогтоосон байдаг. Нэхэмжлэгч байгууллага нь МХБ-ийн журамд заасан 1 хувь гэх үйлчилгээний хөлс, хэмжээг урьдчилан мэдэж, ойлгож, харилцан зөвшөөрч бүртгэлийн гэрээ байгуулсан.

ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсний хувь хэмжээ өөрчлөгдсөн нь гагцхүү батлагдсан үеэсээ хүчин төгөлдөр болох ба батлагдахаас өмнөх хугацаанд ухарч үйлчлэхгүй.

Харин Санхүүгийн зохицуулах хорооноос МХБ-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор батлагдсан хувь хэмжээгээр “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-с бүртгэх үйлчилгээний хөлсийг хураах талаар шийдвэр гаргасан тохиолдолд бид эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, зохих ёсоор шийдвэрлэх боломжтой юм.

Дээр дурдсан нөхцөл байдалд үндэслэн “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг даалгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг өнөөдрийн байдлаар хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.” гэв.

3.2 *Хариуцагч бөгөөд хариуцагч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:*

“Хариуцагчийн эрх зүйн байдлын талаар товч танилцуулъя. Хариуцагч Монголын хөрөнгийн бирж нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авдаг. Энэ салбарын хувьд төрийн зохицуулах гол байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо гэж явдаг. Монголын хөрөнгийн бирж бол анх Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар орохдоо 100% төрийн өмчид хувьцаат компани байсан. Хувьцааг Монгол Улсын Засгийн газар төлөөлж Сангийн яам эзэмшдэг байсан. Өнгөрсөн жил хөрөнгийн биржээр санал болгосон. Одоо бол хувьцааны хувьд 66 хувийг Сангийн яам эзэмшиж байгаа. 34 хувийг олон нийт эзэмшиж байгаа. Нэхэмжлэгч олон нийтийн олон хувьцаа эзэмшигчтэй гэх агуулгаар нэхэмжлэл гаргаж байгаа учраас Монголын хөрөнгийн бирж мөн адил 34 хувийг Монгол Улсын ард иргэд эзэмшдэг 66 хувийг Сангийн яам эзэмшдэг. 100 хувь төрийн өмчид компани байхаа больсон.

Энэ маргаанд Монголын хөрөнгийн биржийн зүгээс анх орохдоо захиргааны хэргийн маргаан мөн үү гэдэг дээр тайлбар өгч мэтгэлцэж явсан. Үүн дээр давж заалдах шатны шүүх тодорхой дүгнэлт хийж анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож буцааж байсан. Үүн дээр магадлалд дурдсан байдаг. Холбогдох хуулийн зохицуулалтыг харах юм бол энэ маргаантай холбоотой харилцаа бол ганцхан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль байгаа юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар арилжаа эрхлэх байгууллага буюу хариуцагч Монголын хөрөнгийн бирж ямар эрх үүрэгтэй тухайн үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо ямар эрх үүрэгтэй оролцох талаар тусгайлсан хуулиар зохицуулсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар талуудын хооронд гарсан маргааныг эхний ээлжид Санхүүгийн зохицуулах хорооны маргаан таслах зөвлөл шийдвэрлэхээр байгаа. Хавтаст хэргийг харах юм бол нэхэмжлэгчийн зүгээс хэзээ ч Маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж байсан зүйл байхгүй. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албанд гаргаж байсан хүсэлт байдаг. Хариуцагчийн зүгээс юу гэж үзэж байгаа вэ гэхээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар тусгайлсан зохицуулсан харилцааны хувьд захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаагүй гэдэг тайлбар гаргаж байна.

Хоёрдугаарт энэ хэрэг маргааны тухайд урьд өмнө нь захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэж байх хугацаанд нэхэмжлэгч өөрөө нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан үйл баримт байгаа. Энэ хэрэг дээр нэг л журмын асуудал яригддаг. Монголын хөрөнгийн биржээс 2019 онд баталсан хураамжтай холбоотой асуудал юм. Энэ хураамжийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн. Санхүүгийн зохицуулах хороо манай журмыг хүлээж аваад батламжилсан. 2021 оны 12 сард хураамжтай холбогдох өөрчлөлт оруулж хураамжийг хэмжээг багасан. Одоо бол нэхэмжлэлийн гол шаардлага юу вэ гэхээр хуучин байгаа журмаар хураамж авах нь одоогийн шинэ баталсан журмаар авах ёстой гэж маргаж байгаа. Цаг хугацааны хувьд Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК нь өмнөх 2019 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан журмын хүчинтэй байх хугацаанд манайд бүртгүүлээд бүртгэлийн гэрээ байгуулсан. Тийм учраас тухайн журмын дагуу төлөх ёстой. Өнөөдөр бол төлсөн байх ёстой. 2021 оны 12 сард өөрчлөлт оруулсан журам бол Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-ийн бүртгүүлсний дараа сүүлд батлагдсан журам юм. Тэгэхээр уг нь бол төлсөн байх ёстой байтал төлөхгүй явсаар байгаад 2021 оны 12 сард манай журамд өөрчлөлт оруулсан гэтэл танайх хуучин журмаар одоо төлнө гэдэг асуудал яриад байгаа. Хариуцагчийн зүгээс юу гэж үзэж байгаа вэ гэхээр захиргааны хэргийн шүүхэд журам хооронд хувь хэмжээний асуудлыг танайх ийм хувь хэмжээгээр төлөх ёстой байна гэдэг шийдвэр гаргах эрх хэмжээ байгаа юу гэдгийг анхаарч үзнэ үү. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг харахаар 63.8-д үүнтэй холбоотой тусгайлсан эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд хуулиар олгосон. 63.1.18-д үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санал болгох, энэ саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох, энэ тухайгаа нийтэд мэдээлэх гэж заасан. Хороонд тусгайлсан заасан байгаа асуудлыг шууд захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэж нэхэмжлэл гаргаж байгаа асуудал өөрөө хууль зүйн үндэслэлтэй юу гэдэг дээр давж заалдах шатны шүүх тодорхой хэлж байгаа.

Нэхэмжлэгч болон хариуцагч нарын хооронд гэрээний харилцаа үүсэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол нэхэмжлэгч компани Монголын хөрөнгийн биржид бүртгүүлээд гэрээ байгуулсан. Гэрээнд зааснаар нэг хувь төлнө гээд гэрээнд

тусгайлан заасан. Тэгэхээр энэ гэрээний эрх зүйн үр дагавар энэ нь одоо хүчинтэй болох юм уу хүчингүй гэж үзээд байгаа юм уу үүн дээр нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага ч тодорхойгүй байгаад байгаа юм. Давхар иргэний эрх зүйн асуудал үүсчихсэн байна. Захиргааны хэргийн шүүхээр шууд шийдвэрлэх ийм хууль эрх зүйн боломж харагдахгүй байгаа юм.

Гуравдугаарт нэхэмжлэлийн шаардлага дээр нэг хувь тогтоосон хураамж анхнаасаа эдийн засгийн үндэслэлгүй энэ хураамжийг төлснөөр сан шууд одоо үйл ажиллагаа явуулах төлбөрийн чадваргүй болох ийм эрсдэлтэй гэдэг ийм агуулга бол дурдаад байгаа юм. Үүн дээр тайлбар хэлэхэд хөрөнгө оруулалтын сан ялангуяа 50 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх зорилготой хөрөнгө оруулалтын сан бол 7 хоногийн дотор ч юм уу өдрийн дотор шууд үүсгэн байгуулагддаггүй. Сан үүсгэн байгуулахын тулд эхлээд зах зээлийн судалгаа хийдэг хууль эрх зүйн судалгаа хийдэг үүнтэй холбоотой бизнес төлөвлөгөө гаргаж танилцуулга хийж санхүүгийн тайланд тооцоо буюу маш олон процессыг дамждаг. Тэгэхээр энэ сан үүсгэн байгуулахаасаа өмнө МХБ-д нэг хувийн үйлчилгээний шимтгэл төлөх юм байна гэдгийг анхнаасаа мэдэж байсан. Ямар баримтаар нотлогдох вэ гэхээр Санхүүгийн зохицуулах хорооноос сая гаргуулсан нотлох баримтууд байгаа. Түүн дотор нэхэмжлэгчийн нэгж эрхийн танилцуулга байдаг. Тухайн нэгж эрхийн танилцуулгыг санд үүсгэн байгуулаад МХБ-д 500 сая төгрөгийн хураамж төлөх юм гэж танилцуулга дээрээ тусгагдсан байгаа юм. 2 дугаарт бизнес төлөвлөгөө гаргасан энэ бизнес төлөвлөгөөний сан дараагийн 5 жил ямар ашиг орлоготой ажиллах вэ ноогдол эрх эзэмшиж байгаа хүмүүстээ ямар хэмжээний хураамж ноогдол ашиг өгөх юм энэ сантай холбоотой ямар зардал гарах вэ гэдэг бизнес төлөвлөгөөг бас тусгайлан заачихсан. Энэ бизнес төлөвлөгөөнд сан үүсгэн байгуулахдаа хуулийн үйлчилгээний зардал гэж төлдөг. Стадион, банкны зардал, хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний зардал МХБ-д төлөх хураамж гээд бүх зардлууд бизнес төлөвлөгөөнд тусгачихсан МХБ-д 500 сая төгрөгийн зардал төлнө. Үүнтэй холбоотойгоор нэхэмжлэгчийн хүсэлт ийм хэмжээний ашиг орлоготой ингэж ажиллана гэсэн бүх санхүүгийн тооцоолол бас гаргачихсан байна. Үүнийг нотлох баримт шинжлэн судлахад тодорхой болох байх. Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна гэхээр энэ 50 тэрбум төгрөгийн иргэдээс татан төвлөрүүлж байгаа сан бол анхнаасаа энэ хэмжээний хураамж төлөөд цаашдаа ийм байдлаар явна гэдэг санхүүгийн тайлан тооцооллоо өөрсдөө гаргаад бизнес төлөвлөгөөгөө гаргаад Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрлөө аваад манайд хандчихсан мөртөө одоо энэ хураамжийг төлөх юм бол бид ийм болох гээд байна гэдэг энэ нэхэмжлэлийн шаардлага үндэслэлгүй байна.

Хоёрдугаарт ер нь бол нэгж эрхийн танилцуулга болон бизнест хөдөлгөөнд зааснаар зөвхөн манайд биш өөр нэлээн хэдэн газруудад ийм хэмжээний хураамж төлөөд явж байгаа ийм асуудлууд байгаа. Сая МХБ-ээс танайд захиргааны хэргийн шүүхээс тодорхойлолтоор өгсөн гэрээн дээр хүртэл өөр байгууллагад жил бүр нэг хувийн үйлчилгээний хөрөнгө төлөөд л явж байгаа. Тэгэхээр МХБ гээд ТӨХК-д нэг хувь төлөх гэхээр үйл ажиллагаа явуулах боломжгүй болчхоод байдаг өөр компанид болохоор төлөөд яваад байдаг ийм асуудал болоод тайлбар үндэслэлгүй бодит байдлын хувьд ч тэр хууль зүйн хувьд ч тэр хүлээн зөвшөөрөхөд боломжгүй гэж үзэж байна” гэв.

4. Иргэдийн төлөөлөгч Ү.Уранцэцэг шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтдээ:

“Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-ийн нэхэмжлэлтэй, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д холбогдох хэрэгт иргэдийн төлөөлөгчөөр оролцлоо. Нэхэмжлэгч хариуцагчдын тайлбар болон хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн тухайн нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэхэд хангалттай гэж үзэж байна. Тухайн хэрэгт авагдсан нотлох баримтуудаар нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй гэж үзэж байна” гэв.

ҮНДЭСЛЭХ нь:

1. “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-иас “Монголын хөрөнгийн бирж” ХК-д холбогдуулан “Монголын хөрөнгийн бирж ХХК-ийн төлөөлөх удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дах заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, нэхэмжлэгчийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6.2.2-т заасан хувиар хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д даалгах” тухай нэхэмжлэлийн шаардлага гаргаж, нэхэмжлэлийн үндэслэлээ “хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгүүлэх үйлчилгээний хураамжийг нэг хувийг төлөхөөр хатуу тогтоосон нь эдийн засгийн үндэслэлгүй бөгөөд хариуцагчаас бидний гомдлын дагуу үйлчилгээний хураамжийн хэмжээг багасгасан тул багасгасан хувь хэмжээгээр үйлчилгээний хөлсийг төлөх ёстой” гэх агуулгаар тайлбарлан маргаж байгаа нь үндэслэлгүй байна.

Нийтийн эрх зүйн маргаан болох тухайд:

2. “Монголын хөрөнгийн бирж” ХК нь хэдийгээр ашгийн төлөө хуулийн этгээд боловч Үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27-д заасанчлан тухайн биржийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл хөтлөх, 4.1.28-д заасанчлан үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулдаг зохицуулалттай этгээд байх тул Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг ... нийтийн эрх зүйн байгууллага”-д тооцогдох тул тухайн биржээс үнэт цаасны бүртгэлийн үйлчилгээний хөлсийг нэхэмжилсэн шийдвэр нь захиргааны актад тооцогдоно.

3. Нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хөрөнгө оруулалтын сан” ХХК-иас 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 22/80 тоот албан бичгээр Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт “үйлчилгээний хураамжийг хэт өндөр тогтоосон” талаар хүсэлт гаргасан байх тул нэхэмжлэгч нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.3-т заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журам хангасан гэж үзэхээр байна.

4. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1-д заасны дагуу гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад хандсан, уг байгууллагаас “Үнэт цаасны зах зээлийн маргаан таслах зөвлөлийн үйл, ажиллагааны журамд заасны дагуу нэхэмжлэгч хуулийн этгээдийн гомдлыг маргаан таслах зөвлөлөөр шийдвэрлүүлээгүй боловч гомдлыг хангасан агуулга бүхий чиглэлийг хариуцагч захиргааны байгууллагад хүргүүлсэн байх тул урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмыг хэрэгжүүлэх боломжгүй байна.

5. Иймд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах” талаарх тайлбарыг үл харгалзан хэргийг хэлэлцэж, маргааныг эцэслэн шийдвэрлэв.

Нэхэмжлэл үндэслэлгүй тухайд:

6. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК/хувьцаат компани болон өөрчлөн байгуулагдсан/-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг баталсан байх ба тус журмын 6.2.2-т “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%” байхаар зохицуулжээ.

7. “Мандал ирээдүйн өсөлт хамтын Хөрөнгө оруулалтын сан” ХХК нь 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх” чиглэлээр анх байгуулагдаж, 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-тай “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн гэрээ”-г байгуулжээ/1хх 112-117 дахь талд/.

8. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 224 дүгээр тогтоолоор “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн байгуулж буй Мандал ирээдүйн өсөлт хаалттай хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт баримт бичгийг, 257 дугаар тогтоолоор тус сангийн нэгж эрхийн танилцуулгыг тус тус бүртгэж, 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 328 дугаар тогтоолоор “Мандал ирээдүйн өсөлт хамтын Хөрөнгө оруулалтын сан” ХХК-д үнэт цаасны зах зээлд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож шийдвэрлэжээ/2хх 34-37 дахь талд/.

8. Нэхэмжлэгч хуулийн этгээд нь дээрх 257 дугаар тогтоолоор бүртгэгдсэн “Мандал ирээдүйн өсөлт хамтын Хөрөнгө оруулалтын сан”-ийн нэгж эрхийн танилцуулгадаа “санг байгуулах, хөрөнгө босгохтой холбоотой нэгж удаагийн шинж чанартай зардал, үүний дотор Монголын хөрөнгийн бирж/МХБ/-ийн бүртгэлд 500 сая төгрөг 2021 оны 6 болон 7 дугаар сард гарах”-аар төлөвлөсөн байна.

9. Энэ тохиолдолд нэхэмжлэгч хуулийн этгээдээс “Монголын хөрөнгийн бирж” ХХК-ийн төлөөлөх удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дах заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох” нэхэмжлэл гаргаж, маргаж байгаа нь үндэслэлгүй байна. Учир нь:

9.1. Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-т “Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг буцаан хэрэглэхгүй” гэж заасан бөгөөд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2019/07 тогтоолоор батлагдсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам” нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдсөн байх тул хариуцагчаас хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан журамд заасан хэмжээгээр бүртгэлийн хураамж төлөхийг шаардсаныг хууль бус байсан гэж үзэх үндэслэлгүй.

9.2. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч нь хамтын хөрөнгө оруулалтын санг анх байгуулахдаа Монголын хөрөнгийн биржийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжид 1 хувийн хураамж төлөхөө мэдэж, төлөвлөсөн байсан бөгөөд уг хураамжийг төлөхөөр гэрээ байгуулж, биржид бүртгүүлсний дараа хураамжийн хэмжээг эс зөвшөөрч маргасан байх тул хариуцагч “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас төлөөлөн удирдах зөвлөлийн 2019/07 тогтоолоор батлагдсан батлагдсан журамд заасан хэмжээгээр хураамж төлөхийг шаардсан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1-д “үнэт цаас болон бараа бүтээгдэхүүнд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийг хөрөнгийн биржээр арилжихад зохих үйлчилгээг үзүүлэх” эрх хэмжээний хүрээнд гарсан шийдвэр байна.

9.3. Хэдийгээр “Мандал ирээдүйн өсөлт хамтын Хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн гаргасан гомдлын дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/4258 тоот албан бичгээр “... хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг хэт өндрөөр буюу 1 хувиар тогтоосон нь бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад 10 дахин их байх бөгөөд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо өсөхгүй байх, зах зээлд оролцогч, хөрөнгө оруулагчдын идэвх сонирхол буурах, улмаар хувийн хэвшлээс нийтэд санал болгосон үнэт цаас гаргахтай холбоотой зардал, өртгийг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. ... иймд үйлчилгээний хөлсний хэмжээг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан

бууруулах арга хэмжээг зохион байгуулах"-гэсэн чиглэлийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-д өгсөн, улмаар тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар уг хураамжийн хэмжээг хэлэлцэж 2019/07 тогтоолоор журам батлах үед 50 тэрбум төгрөгийн хамтын хөрөнгө оруулалтын сан гарна гэсэн хүлээлт байгаагүйгээс хураамжийн хэмжээ ялгаваргүйгээр тогтоогдсоныг хүлээн зөвшөөрч нэгж эрхийн бүртгэлийн хураамжийн хэмжээг багасгаж шийдвэрлэсэн байх боловч энэ нь журмын зохицуулалтыг буцааж хэрэглэх үндэслэл болохгүй.

9.4. Өөрөөр хэлбэл, "Монголын хөрөнгийн бирж" ХК-иас нэхэмжлэгчийн гаргасан хүсэлт, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн чиглэлийн дагуу 2021 оны 16 дугаар тогтоолоороо нэгж эрхийн бүртгэлийн хураамжийн хэмжээг бууруулж шийдвэрлэсэн боловч энэхүү бууруулсан хувь хэмжээ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хойш байгуулагдсан хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлд хамаарах тул 16 дугаартай тогтоол гарахаас өмнөх цаг хугацаанд бүртгэгдсэн нэгж эрхийн бүртгэлтэй холбоотой үйл баримтад хамаарахгүй юм.

10. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс "хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгүүлэх үйлчилгээний хураамжийг нэг хувийг төлөхөөр хатуу тогтоосон нь эдийн засгийн үндэслэлгүй" хэмээн тайлбарлан маргах боловч "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 2019/07 дугаар тогтоолоор батлагдсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6.2.2-т "Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%" гэж зохицуулсан нь эдийн засгийн үндэслэлтэй эсэхэд анхан шатны шүүхээс дүгнэлт хийх эрх хэмжээгүй.

11. Мөн дээрх журам нь захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэгдээгүй болох нь Хууль зүй дотоод хэргийн яамнаас 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн лавлагаагаар тогтоогдож байх боловч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.4-т "энэ хуульд заасны дагуу хөрөнгийн бирж батлахаар заасан дүрэм, журмыг болон тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг зохих журмын дагуу Хороогоор батламжлуулах"-аар нарийвчлан зохицуулсан, үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн 537 дугаар тушаалаар уг журмыг батламжилсан байх тул уг журмын хүчин төгөлдөр байдлыг үгүйсгэх боломжгүй.

12. Мөн нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс "хариуцагчаас бидний гомдлын дагуу үйлчилгээний хураамжийн хэмжээг багасгасан тул бид Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан" хэмээн тайлбарлан маргах боловч журмын 6.2.2-т "Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%" гэж заасныг хууль бус байсан болохыг тогтоолгохоор маргаагүй, Захиргааны хэргийн давж заалдах шатны шийдвэрлүүлээгүй байх тул энэ үндэслэлээр 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөгдсөн хувь хэмжээгээр хураамж төлүүлэхийг даалгах үндэслэлгүй юм.

13. Дээр дурдсан үндэслэлүүдээр иргэдийн төлөөлөгчийн "... нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй гэж үзэж байна" гэсэн дүгнэлтийг хүлээж авах үндэслэлгүй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

14. Иймд "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан ХХК-ийн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус болохыг тогтоолгох, тус зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан Хамтын хаалттай хөрөнгө

оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар үйлчилгээний хөлс хураахыг “Монголын Хөрөнгийн бирж” ХК-д даалгах” тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3.14-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-т заасныг тус тус баримтлан “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-иас “Монголын хөрөнгийн бирж” ХК-д холбогдуулан гаргасан ““Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөх удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар хувьцаат хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6.2.2-т заасан хуваарь хураахыг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д даалгах” тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70 200 төгрөгийг улсын төсвийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1-д заасны дагуу хэргийн оролцогчид, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нь шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор давж заалдах журмаар гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

ШҮҮГЧ

ШҮҮГЧ

Ц.МӨНХЗУЛ

Л.БАТБААТАР

Д.ЧАНЦАЛНЯМ





ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 221/МА.2023/0704

Улаанбаатар хот

“Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС”
ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн давж заалдах журмаар хэргийг шийдвэрлэсэн

Шүүх бүрэлдэхүүн:

Шүүх хуралдаан даргалагч Ерөнхий шүүгч Д.Баатархүү

Бүрэлдэхүүнд оролцсон шүүгч Б.Тунгалагсайхан

Илтгэсэн шүүгч Г.Билгүүн

Давж заалдах гомдол гаргасан хэргийн оролцогч:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайхан

Нэхэмжлэлийн шаардлага: “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, нэхэмжлэгчийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6.2.2-т заасан хувиар хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д даалгах

Давж заалдах гомдол гаргасан шүүхийн шийдвэр: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 757 дугаар

Давж заалдах шатны шүүх хуралдааны оролцогчид:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайхан

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга С.Номуунаа

Хэргийн индекс: 128/2022/0888/3

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-иас “Монголын хөрөнгийн бирж” ХК-д холбогдуулан “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, нэхэмжлэгчийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын

221014833

сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6.2.2-т заасан хувиар хураахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-д даалгуулах"-аар маргасан байна.

2. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 757 дугаар шийдвэрээр: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-т заасныг тус тус баримтлан "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-иас "Монголын хөрөнгийн бирж" ХК-д холбогдуулан гаргасан "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төлөөлөх удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар хувьцаат хавсралтаар баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, эрхийн бүртгэлийн хураамжийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6.2.2-т заасан хуваарь хураахыг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д даалгах тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

3. Давж заалдах гомдлын агуулга: Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч дараах үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж байна. Үүнд:

"Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК нь "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус болохыг тогтоолгох, "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь хэсэгт заасан хувиар хураахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-д даалгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан.

Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн хураамж хэт өндөр, эдийн засгийн тооцоо судалгаагүй хийгдсэн талаар "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК нь Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны газарт хүсэлт гаргаж байсан боловч хариу өгөөгүй эс үйлдэхүй гаргасан. Хүсэлтийг тухайн байгууллагууд өөрсдийн дотоод бүтцийн нэгждээ дамжуулан шийдвэрлэх боломжтой байсаар атал энэ асуудлыг огт шийдвэрлээгүй билээ.

Манай хөрөнгө оруулалтын сангийн зүгээс Санхүүгийн зохицуулах хороонд уг журмаар тогтоосон хураамжийн хэмжээг багасгах талаар "Монголын хөрөнгийн бирж" ХК-д даалгуулах, хэмжээг бууруулах талаар хандсан боловч шийдвэрлэхгүй эс үйлдэхүй гаргасан тул захиргааны хэргийн шүүхэд хандсан юм. Үнэт цаасны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.18-д заасан Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрхэд "үнэт цааны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санал болгох, энэ саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох, энэ тухайгаа нийтэд мэдээлэх, 74 дүгээр зүйлийн 4-д "Хороо хууль тогтоомжтой зөрчилдсөн дүрэм, журмыг бүхэлд нь, эсхүл тэдгээрийн зарим заалтыг өөрчлөх даалгавар өгч болно" гэсэн эрхийг олгосон заалтууд байсаар байтал энэ эрхээ хэрэгжүүлээгүй эс үйлдэхүй гаргасан.

Нэхэмжлэгч тал хэргийн харьяалал болон урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулсан эсэхэд хийсэн анхан шатны шүүхийн дүгнэлттэй маргахгүй.

Анхан шатны шүүх хэргийг анхан шатны журмаар хэлэлцэж шийдвэрлэхдээ “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалт нь нэхэмжлэгчийн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хангасан эсэхэд дүгнэлт хийхгүйгээр шийдвэрлэсэнд гомдолтой байна.

Иймд дээрх үндэслэлүүдээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1.2-т заасны дагуу Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 757 дугаартай шийдвэрийг хүчингүй болгуулахаар энэхүү давж заалдах гомдлыг гаргаж байна” гэжээ.

ХЯНАВАЛ:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3-д заасны дагуу хэргийг хянаад шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэлээ.

2. Шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нарын давж заалдах гомдлыг хангах үндэслэлгүй гэж үзэв.

2.1. Нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-иас “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, нэхэмжлэгчийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6.2.2-т заасан хувиар хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д даалгах” гэж нэхэмжлэлийн шаардлагаа тодруулан маргажээ.

2.2. Хэрэгт авагдсан баримтуудаас үзэхэд, нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК нь 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр анх хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр байгуулагдаж, улмаар 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр 2021/72 дугаар “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн гэрээ”-г “Монголын хөрөнгийн бирж” ХК-тай байгуулсан байна.

2.3. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2-т “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%” гэж заасан. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ийг нэгж эрхээ бүртгүүлэх үед дээрх журмын зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж байжээ.

2.4. Түүнчлэн нэхэмжлэгчээс анх Санхүүгийн зохицуулах хороонд хаалттай хамтын хөрөнгө оруулалтын санг бүртгүүлэх үед гаргаж өгсөн Нэгж эрхийн танилцуулгадаа “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн бүртгэлийн хураамж 1% 500,000,000 төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн байх төдийгүй “Монголын хөрөнгийн бирж” ХК-тай 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр 2021/72 дугаар “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн гэрээ”-ний 2.1.2-т “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь” гэж тусгажээ.

2.5. Өөрөөр хэлбэл, хариуцагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-д “Хөрөнгийн бирж үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй” гэж хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд үйлчилгээнийхээ хөлсийг тогтоосон, мөн нэхэмжлэгчээс анх хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулахдаа Монголын хөрөнгийн биржийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжид 1 хувийн хураамж төлөхөө мэдэж, төлөвлөсөн байсан бөгөөд уг хураамжийг төлөхөөр гэрээ байгуулж, нэгэнт биржид бүртгүүлсэн байгаа энэ тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах хууль зүйн үндэслэлгүй.

2.6. Хэдийгээр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор “...тус зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгээс хамаарч: 6.2.2.1-д “20 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.5%”, 6.2.2.2-т “20-50 тэрбум хүртэлх үнийн дүнд 0.375%”, 6.2.2.3-д “50 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнд 0.25%” гэж өөрчилсөн байх боловч энэ нь нэхэмжлэгч компанийн уг тогтоол батлагдахаас өмнө бүртгүүлсэн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсийг буруулах үндэслэл болохгүй бөгөөд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн “ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлсний хувь хэмжээ өөрчлөгдсөн нь гагцхүү батлагдсан үеэсээ хүчин төгөлдөр болох ба батлагдахаас өмнөх хугацаанд ухарч үйлчлэхгүй” гэх тайлбар үндэслэлтэй.

Анхан шатны шүүх маргааны үйл баримтыг зөв тодорхойлж, шаардлагатай нотлох баримтуудыг цуглуулан, уг баримтуудад үндэслэл бүхий дүгнэлт хийсэн байх боловч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт хэргийг хянан шийдвэрлэхэд баримталбал зохих хуулийн зохицуулалтыг баримтлахгүй орхигдуулсан, мөн утга найруулгын алдаа гаргасан байх тул давж заалдах шатны шүүхээс шүүхийн шийдвэрт зөвтгөсөн өөрчлөлтийг оруулж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхихоор шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 120 дугаар зүйлийн 120.3-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 757 дугаар шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1, 49.3, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөл хамтын ХОС” ХХК-иас “Монголын хөрөнгийн бирж” ХК-д холбогдуулан гаргасан ““Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, нэхэмжлэгчийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6.2.2-т заасан хувиар хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй

болгосугай” гэж өөрчилж, тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-д заасныг баримтлан нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс давж заалдах гомдол гаргахдаа төлсөн 70200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж хэргийн оролцогч нар үзвэл магадлалыг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БААТАРХҮҮ

ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН





МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 001/ХТ2024/0019

Улаанбаатар хот

“Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ийн
нэхэмжлэлтэй, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д
холбогдох захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх
хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч: Г.Банзрагч

Шүүгчид: Д.Батбаатар

М.Батсуурь

Ц.Цогт

Илтгэгч шүүгч: Х.Батсүрэн

Нарийн бичгийн дарга: Л.Содномдорж

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар
сарын 12-ны өдрийн 128/ШШ2023/0757 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын
29-ний өдрийн 221/МА2023/0704 дүгээр магадлал,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн
хуралдааны 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 19 дүгээр хэлэлцүүлэх
тогтоолтой хэргийг, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайхан,
хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ундрах-Эрдэнэ нарыг оролцуулан
нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлоор
хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Нэхэмжлэлийн шаардлага:

1. “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-аас “Монголын хөрөнгийн бирж”
ХК-д холбогдуулан “... “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын
хавсралтаар баталсан “... Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж
эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар
бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, эрхийн

151700900022

бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад заасан хувиар хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгах” шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ.

Хэргийн нөхцөл байдал:

2.“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг хавсралтаар баталжээ. Тус журмын 6 дугаар зүйлийн 6.2-т “Санд Биржээс үзүүлэх үйлчилгээний хөлс нь дараах төрөлтэй байна.”, 6.2.2-т “Нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс-Нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1%,” гэж заажээ.

3.Нэхэмжлэгч компаниас “... нэгж эрхийг бүртгэх үйлчилгээний хөлсийг 1 хувь байхаар журамласан нь хуулиар олгосон эрхийн хүрээнд боловч эдийн засгийн тооцоо, судалгаа, үндэслэлгүйгээр хөлсийг нэмэгдүүлсэн, энэ нь хөрөнгийн зах зээлд оролцогч компанийн эдийн засгийг илт хохироосон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй, хувьцаа болон бондын хураамжийг 0.1% хувь буюу 50 сая төгрөгөөс хэтрэхгүй гэж тогтоосон харин сангийн нэгж эрхээ 1 хувь гэж дээшээ лимитгүй тогтоосон нь үндэслэл бүхий биш, Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн 2021 оны 16 дугаар тогтоолоор нэгж эрхийн бүртгэлийн үйлчилгээний хөлсийг журамласан 2019/07 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан, уг өөрчлөлт оруулсан үйлчилгээний хөлсөөр төлөх талаар удаа дараа хүсэлт гаргасан, хүсэлтийг хүлээж аваагүй шударга бус, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дахь заалтыг 2022 оны хуулиар өөрчлөлт оруулсан тул хүчингүй болсон журмын холбогдох хэсгийг буцаан хэрэглэх нь хууль бус; 2019 оны журмын заалтаар хураамж авах нь хууль бус, 2021 оны 16 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан хувиар хураах нь зүйтэй ...” гэж;

3.1.Хариуцагчаас “... хуульд зааснаар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийлгээгүй, маргааныг урьдчилан шийдвэрлэх эрх бүхий Санхүүгийн зохицуулах хорооны Маргаан таслах зөвлөлд хандаагүй, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь улсын хэмжээнд эсхүл засаг захиргааны нутаг дэвсгэрийн аль нэг нэгжийн хүрээнд хэм хэмжээ тогтоох эрхтэй субъект биш, уг ТУЗ-өөс 2019 онд баталсан Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгжийн эрхийн бүртгэлийн журам нь зөвхөн манай хөрөнгийн биржид бүртгүүлсэн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх дотоодод чиглэсэн хэм хэмжээ юм, манай хөрөнгийн биржид бүртгүүлээгүй хөрөнгө оруулалтын сангуудад тус журам хамааралгүй бөгөөд дагаж мөрдөгдөхгүй, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.1-т зааснаар хэм хэмжээний акт гэдэгт хамааралгүй, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1-д зааснаар үнэт цаасны 17 зохицуулалттай үйл ажиллагаа байгаа, Монголын хөрөнгийн бирж нь уг 17 үйл ажиллагааг Хороос авсан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулах ба төрийн өмчит хуулийн этгээд

эсхүл хувийн хэвшлийн байгууллага аль аль нь эрхлэн явуулах боломжтой ба үүнд өмчийн хязгаарлалт тогтоогоогүй;

-Монголын хөрөнгийн бирж нь хувийн эрх зүйн салбар буюу үнэт цаасны зах зээлийн харилцаанд бусад хувийн хэвшлийн зарим байгууллагатай өрсөлдөн ажилладаг байгууллага, Монголын хөрөнгийн биржийн хувьцааг төрийг төлөөлж Сангийн яам эзэмшдэг бөгөөд МХБ-ийн ТУЗ-ийг Сангийн яамнаас томилогдсон этгээдүүд хэрэгжүүлдэг, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад үйл ажиллагаагаа явуулдаг, Төр аливаа компанийн хувьцааг эзэмшдэг байснаараа тухайн компани захиргааны байгууллага гэж тооцогдохгүй, журам нь тухайн зохицуулалттай этгээдийн зөвхөн өөрийнх нь харилцагч үйлчлүүлэгчийн хүрээнд мөрдөгдөх дотогшоо чиглэсэн үйлчлэл бүхий хэм хэмжээний акт тул захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлгүй, Монголын хөрөнгийн биржийн дүрмийн 7.3.16-д зааснаар журам батлах эрх ТУЗ-д олгосон, Монголын хөрөнгийн бирж нь хамтын хаалттай ХОС-ийн нэгж эрхийн бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон журмыг 2019 онд баталж, хуульд зааснаар Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулахаар хүргүүлж, хороо батламжилсан, Монголын хөрөнгийн бирж нь бүртгэх үйлчилгээний хөлсийг Засгийн газрын бодлого, хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд нийцүүлж боломжит хэмжээгээр бууруулах байр суурьтай байж, хувь хэмжээг бууруулах эрх бүхий субъект болох ТУЗ-д удаа дараа оруулж хэлэлцүүлсэн, үүний дагуу Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6.2.2-т өөрчлөлт оруулж баталсан, нэхэмжлэгч компанитай байгуулсан хамтын хөрөнгө оруулалтын сангийн бүртгэлийн гэрээний 2.1.2-т бүртгэх үйлчилгээний хөлсийг 2019 оны 2019/07 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2.2-т заасан 1 хувиар тооцохоор тогтоосон, гэрээ байгуулагдах үед мөрдөгдөж байсан журмын дагуу хураамжаа төлөх нь үндэслэлтэй;

-Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 16 дугаар тогтоолоор баталсан журмаар бүртгэлийн үйлчилгээний хөлсний хувь хэмжээ өөрчлөгдсөн нь гагцхүү батлагдсан үеэсээ хүчин төгөлдөр ба батлагдахаас өмнөх хугацаанд ухран үйлчлэхгүй, Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан хувь хэмжээгээр тус компаниас бүртгэх үйлчилгээний хөлсийг хураах талаар шийдвэр гаргасан тохиолдолд бид эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, зохих ёсоор шийдвэрлэх боломжтой ..." гэж тус тус тайлбарлан маргажээ.

4.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-т заасныг тус тус баримтлан "Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан" ХХК-иас "Монголын хөрөнгийн бирж" ХК-д холбогдуулан гаргасан "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төлөөлөх удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар хувьцаат хавсралтаар баталсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, эрхийн бүртгэлийн

хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын 6.2.2-т заасан хуваарь хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгах” тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

5.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар: Анхан шатны шүүхийн шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1, 49.3, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөл хамтын ХОС” ХХК-иас “Монголын хөрөнгийн бирж” ХК-д холбогдуулан гаргасан ““Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, нэхэмжлэгчийн нэгж эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6.2.2-т заасан хувиар хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчилж, тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

6.Нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайханы хяналтын журмаар гаргасан гомдлыг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын дээд шүүх хүлээн авч, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх”, “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой эсэх” гэсэн үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл:

7.Нэхэмжлэгч “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.Баярсайханаас шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгуулахаар дараах хяналтын гомдлыг (агуулгаар нь тусгав) гаргажээ. Үүнд:

7.1.Нэхэмжлэгч компани нь Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны газарт (маргаж байгаа журмын хураамжийн хэмжээг бууруулах талаар) хүсэлт гаргаж байсан боловч хариу өгөөгүй эс үйлдэхүй гаргасан. Бид энэ асуудлаар Санхүүгийн зохицуулах хороонд 2022 оны 10 дугаар сард дахин хандсан боловч одоог хүртэл хариу өгөөгүй. Мөн энэхүү маргаан бүхий асуудал нь Санхүүгийн зохицуулах хорооны Маргаан таслах зөвлөлийн харьяалан шийдвэрлэх асуудал биш гэдгийг анхан шатны шүүх шийдвэртээ тодорхой тайлбарласан.

7.2.Манай хөрөнгө оруулалтын сангийн зүгээс Санхүүгийн зохицуулах хороонд уг журмаар тогтоосон хураамжийн хэмжээг багасгах талаар “Монголын хөрөнгийн

бирж” ТӨХК-д даалгуулах, хэмжээг буруулах талаар хандсан боловч шийдвэрлэхгүй эс үйлдэхүй гаргасан тул захиргааны хэргийн шүүхэд хандсан юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.18-д заасан Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрхэд “үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санал болгох, энэ саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох, энэ тухайгаа нийтэд мэдээлэх, 74 дүгээр зүйлийн 4-т “Хороо хууль тогтоомжтой зөрчилдсөн дүрэм, журмыг бүхэлд нь, эсхүл тэдгээрийн зарим заалтыг өөрчлөх даалгавар өгч болно.” гэсэн эрхийг олгосон заалтууд байсаар байтал энэ эрхээ хэрэгжүүлээгүй эс үйлдэхүй гаргасан.

7.3.Маргаж байгаа хураамжийн хувь хэмжээ хэт өндөр байгаа талаар бид анхнаасаа байр сууриа илэрхийлж байсан ба давамгай байдалтай хуулийн этгээд болох “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-тай гэрээ байгуулахаас өөр сонголт байгаагүй. Тухайн үед Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг Хөрөнгийн оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэх хуулиар эрх олгож үйл ажиллагаа явуулж байсан ганцхан аж ахуйн нэгж байсан нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК ба бидний зүгээс тэдний тулгасан нөхцөлийг зөвшөөрч бүртгүүлэхгүй бол үйл ажиллагаа явуулах ямар ч боломжгүй байсан болно.

7.4.Тус компани нь 2022 оны 09 дүгээр сард нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх хугацаанд Монгол Улсын Их Хурлаас Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дэх хэсэгт “Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг буцаан хэрэглэхгүй.” гэсэн нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар оруулсан тул энэ зүйлд заасны дагуу хүчингүй болсон журмын холбогдох хэсгийг одоо буцаан хэрэглэх боломжгүй гэж үзэж, анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал үндэслэл бүхий гарсан эсэхэд эргэлзэж байх тул энэхүү хяналтыг гомдлыг гаргаж байна ... гэжээ.

8.Хариуцагч талаас нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдолд холбогдуулж аливаа тайлбарыг бичгээр гаргаагүй байна.

ХЯНАВАЛ:

9.Шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байх тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

10.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар захиргааны хэргийн шүүх нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагаатай холбоотой хүн, хуулийн этгээдээс ... гаргасан өргөдлийг хянан шийдвэрлэдэг.

11.Захиргааны байгууллагыг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг... ойлгоно:” гээд 5.1.1-д “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;”, 5.1.2-т “хууль

тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага;”, 5.1.3-т “захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд;”, 5.1.4-т “үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа;”, 5.1.5-д “нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага” байхаар тус тус заажээ.

12. Энэ хэргийн тухайд, нэхэмжлэгчийн хариуцагчаар тодорхойлсон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн эрх зүйн байдлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулсан бөгөөд хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д “үнэт цаасны зах зээлд оролцогч” гэж үнэт цаас гаргагч, зохицуулалттай этгээд болон хөрөнгө оруулагчийг;”, 4.1.17-д ““зохицуулалттай этгээд” гэж энэ хуулийн 24.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийг;”, 4.1.28-д ““хөрөнгийн бирж” гэж үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;”, 24 дүгээр зүйлийн 24.1-д “Зохицуулалттай үйл ажиллагаанд дор дурдсан үйл ажиллагаа хамаарна.” гээд 24.1.11-д “үнэт цаасны арилжаа эрхлэх;”, 24.2-т “Энэ хуулийн 24.1.1-24.1.14-т заасан үйл ажиллагааг Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ” гэсэн байна.

13. Дээрх хуулийн зохицуулалтаас үзвэл, “хөрөнгийн бирж” нь Санхүүгийн зохицуулах хорооноос (захиргааны байгууллагаас) үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа хийх тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр тухайн зах зээлд оролцож, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хувийн эрх зүйн хуулийн этгээд байна. Энэхүү үйл ажиллагааг “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас гадна хүссэн этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хуульд заасан журмын дагуу явуулах боломжтой, одоогийн байдлаар 2 этгээд (Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж) үйл ажиллагаа явуулж байгаа нь нийтэд илэрхий үйл баримт юм.

14. Монголын хөрөнгийн бирж нь нөгөө биржээс ялгаатай нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар төрийн өмчит үйлдвэрийн газар байсан боловч 2022 онд хувьцаат компани хэлбэрт шилжсэн бөгөөд уг хэргийн хариуцагч гэх “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг “нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд буюу захиргааны байгууллага” гэж үзэхгүй.

15. Түүнчлэн, Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно” гэж заасан энэхүү тодорхойлолтын нэг үндсэн гол шинж нь тухайн шийдвэрийг хуулиар эрх шилжүүлэн авсан “захиргааны байгууллага” гаргах юм.

16. Хэдийгээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т “Хөрөнгийн бирж үзүүлж байгаа үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээг тогтоох эрхтэй” гэж заасан боловч дээр дурдсанаар хөрөнгийн бирж нь захиргааны байгууллага бишээс гадна энэ нь нийтээр заавал дагаж мөрдөх хэм хэмжээ биш,

Хөрөнгийн биржээс үнэт цаасны арилжааны үйлчилгээ үзүүлэхэд тогтоосон байгууллагын дотоод үйл ажиллагаанд чиглэсэн хэм хэмжээ бөгөөд уг үнээр үйлчилгээ авах эсэх нь үнэт цаасны зах зээлд оролцож буй этгээдүүд сайн дурын үндсэн дээр үүсэх хувийн эрх зүйн харилцаанд хамаарахаар байна.

17.Иймд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам” нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулахгүй.

18.Гэтэл анхан шатны шүүхээс “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага” гэж, маргаан бүхий журмыг захиргааны хэм хэмжээний акт гэж буруу дүгнэн, нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэн шийдвэрлэсэн нь үндэслэлгүй, давж заалдах шатны шүүх энэхүү алдааг залруулаагүй байна.


19.Дээрх үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан “захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж дүгнэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2, 127.2.4-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 128/ШШ2023/0757 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 221/МА2023/0704 дүгээр магадлалыг тус тус хүчингүй болгож, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 109 дүгээр зүйлийн 109.2-т заасныг тус тус баримтлан “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-аас “Монголын хөрөнгийн бирж” ХК-д холбогдуулан гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад зааснаар бүртгэлийн хураамж авах нь хууль бус байсан болохыг тогтоолгох, эрхийн бүртгэлийн хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтад заасан хувиар хураахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д даалгах” шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасныг баримтлан нэхэмжлэгчээс хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ		Г.БАНЗРАГЧ
ШҮҮГЧИД		Д.БАТБААТАР
		М.БАТСУУРЬ
		Ц.ЦОГТ
		Х.БАТСҮРЭН

Handwritten signature and scribbles at the bottom of the stamp area.